

Залуусыг хөтлөх хууль

Монгол Улсын нийт хүн амын 35.5 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна >2

Ирэх жилүүдэд ачааны хүндийг тэр л үүрнэ

Элгээрээ хэвтсэн эдийн засгийг босгоод ирвэл түүхэнд түүний нэр үлдэнэ. >3

Шөнийн хөнгөлөлтийг нөхөж тооцно

Эрчим хүчний шөнийн хэрэглээ 15.9 хувиар өсөөд байна. >5



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.02.24, БААСАН ~ №039 (585)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж улсын алдарт болон манлай уяач нарыг шагналаа.

ЕТГ-ын "Төрийн гэрэгэ" шагналын эзнээр "Говь", "Эрдэнэт хивс" компани тодорлоо.

АН-аас нэр бүхий гишүүдийг гүтгэлээ хэмээн УИХ-ын даргад мэдэгдэл хүргэхээр болжээ.

Засгийн газрын хуралдаанаар Сангийн яамны оруулсан төсвийн тодотголыг хэлэлцэж, дэмжив.

Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг Авлигатай тэмцэх газарт байцаалт өгөв.

ЭДИЙН ЗАСАГ

Монголын хөрөнгийн биржийн индекс 847,70 нэгж болж, 1.23 хувиар өсөв.

"Улаанбаатар хивс" хувьцаат компани нийт 30.3 сая төгрөгийг ногдол ашиг тараана.

Валютын дуудлага худалдаагаар Монголбанк 20.6 сая ам.доллар банкуудаас худалдаж авлаа.

"Иргэдийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг дэмжих нь" сэдэвт хэлэлцүүлэг болов.

"Хөрөнгө оруулагч үндэстэн" компани хувьцаагаа оны эхний хагаст нийтэд санал болгоно.

НИЙГЭМ

Өвөлжилт хүндэрсэн 170 суманд Олон улсын байгууллагын тусламжийг хүргэж байна.

Баярын өдрүүдэд автын ослоос сэргэмжлэхийг Цагдаагийн газраас анхаарууллаа.

Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороонд 550 хүүхдийн сургууль, цэцэрлэг нээлтээ хийв.

ХНХЯ, БНСУ руу хэлний мэдлэг сайтай 1500 иргэнийг гэрээгээр ажиллуулахаар болжээ.

Эрдэмтэд БСШУ-ы сайд Ж.Батсуурийг огцрохыг шаардаж, жагслаа.

ДЭЛХИЙ

Путин ОХУ-ын төсвийн зарцуулалтад хяналт тогтоох үүрэг өгсөн байна.

НҮБ-ын тэргүүн терроризмтай тэмцэх шинэ алба байгуулах санал гаргав.

Будапешт 2024 оны Олимпын тоглолтыг зохион байгуулахаас татгалзлаа.

Deutsche Telekom-ийн сүлжээнд нэвтэрсэн хакаерыг Англид баривчлав.

Үерээс болж Калифорнид 14 мянган хүнийг нүүлгэн шилжүүлээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.02.24



-3° | -16°


БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮГЭЭС ҮНШИНЭ ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Цаасан баримтыг халах шинэчлэл



NFC картын технологийг монгол инженерүүд нэвтрүүлэхээр ажиллаж буй бөгөөд иргэд худалдан авалт бүрийн мэдээлээ шивж оруулдаг одоогийн системийг хална. ►11

С.Батсайхан/ЗГМ©

TDBV

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

"Алтан
Унжлагам"
хэрмээх гал
Тахиа жил
2017

САР ШИНЭДЭЭ САЙХАН ШИНЭЛЭЭРЭЙ!

Хөгжил дэвшилд хамтдаа

Утас: 1900-1977 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn
Фэйсбүүк: www.tdbm.mn/facebook | Твиттер: www.tdbm.mn/twitter

Э.Долгион Монголын өдөр тутмын сонинуудын холбоог удирдана



Монголын өдөр тутмын сонинуудын холбооны гишүүд өчигдөр хуралдаж, удирдлагаа шинээр томиллоо. Монголын өдөр тутмын 10 гаруй сонин ерөнхий эрхлэгч нар санал нэгтгэж "Засгийн газрын мэдээ" сонин ерөнхий эрхлэгч Эрдэнэбаатарын Долгионыг Монголын өдөр тутмын сонинуудын холбооны ерөнхийлөгчөөр томилжээ.

"Өнөөдөр", "Өдрийн сонин", "Засгийн газрын мэдээ", "Үндэсний шуудан", "Монголын мэдээ", "Үндэсний мэдээ" тэргүүтэй Монголын өдөр тутмын тэргүүлэх сонинууд эл холбоонд харьяалагддаг ба Монголын хэвлэлийн эрх чөлөө, салбарын хөгжил, сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар нь энэ холбооны үйл ажиллагаатай салшгүй холбогддог юм. Дөрөв дэх засаглалын үүргийг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хариуцлагатай сэтгүүл зүйн тогтолцоог бий болгох, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх зэрэг асуудалд анхаарч ажиллахаа Монголын өдөр тутмын сонинуудын холбооны ерөнхийлөгч Э.Долгион тэмдэглэж байна.

Монголын өдөр тутмын сонинуудын холбооны анхны ерөнхийлөгчөөр нэрт сэтгүүлч Ц.Балдорж агсан томилогдон ажиллаж байсан юм. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд Монголын хэвлэл мэдээллийн салбар, тэр дундаа өдөр тутмын сонин салбарт лидерүүд хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн "Өдрийн сонин"-ы ерөнхий эрхлэгч Ж.Мягмарсүрэн, "Монголын үнэн" сонин ерөнхий эрхлэгч Б.Ганболд, "NEWS" агентлагийн захирал Б.Тэмүүлэн, "Өнөөдөр" сонин нэгдүгээр орлогч эрхлэгч асан С.Батбаатар, "Монголын мэдээ" сонин ерөнхий эрхлэгч С.Гантоогоо, "Үндэсний шуудан" сонин ерөнхий эрхлэгч асан Г.Отгонбаяр болон "Өнөөдөр" сонин ерөнхий эрхлэгч Б.Нандинтүшиг нар томилогдон ажиллаж байв.

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
847.7 1.2%	1237.71 0.02%	6040 0.3%	93.571 0.1%	99.550 0.2%	2473.63	359.70	42.73

Улс төр

ТӨСӨЛ

Залуусыг хөтлөх хууль



Б.Ганбаяр / ЗГМӨ

Монгол Улсын нийт хүн амын 35.5 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна

Б.Даваатогтох
@datoZGM

Нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлох, төрөөс залуучуудад үзүүлэх дэмжлэг, залуучуудын хөгжлийг дэмжих төрийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих

хуулийн төслийг боловсруулсан. Засгийн газраас боловсруулсан энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалыг УИХ дэмжсэн. Ирэх хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөдөг буй.

Монгол Улсыг залуучуудын орон хэмээн нэрийддэг ч өнөөдрийг хүртэл тэдэнд чиглэсэн төрийн бодлого, хууль тогтоомж байсангүй. Өөрөөр хэлбэл, залуучуудын өмнө тулгамддаг олон асуудал шийдлээ хүлээж байгаа юм. Тиймээс залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлж, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн хүчин зүйлийг хуульчилж өгөхөөр дээрх хуулийн төслийг боловсруулсан. Долоон бүлэг, 24 зүйлтэй уг хуулийн төсөл 15-34 насны залуучуудын шийдвэр гаргах түвшин дэх оролцооны хэлбэрийг тодорхойлох юм.



боловсруулсан юм. Зайлшгүй цогц бодлого гаргах, хууль эрх зүйн тодорхой зохицуулалттай болох нийгмийн шаардлага бий болж байна. Хэдий залуучуудын гэх нэршилтэй боловч улс орны хөгжлийн зангилаа асуудлууд багтаж байгаа нь энэ хуулийн амин сүнс гэж хэлж болно.

С.МӨНГӨНЧИМЭГ: ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ БОЛОН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛНА

Энэхүү хуулийн төслийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг дараах зүйлийг тодрууллаа.

-Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага нь юу вэ?

-Энэ хуулийн төслийг манай яамнаас олон талт судалгаа, дэлхий нийтийн чиг хандлага, Монголын залууст тулгарч байгаа түгээмэл асуудлууд гээд зайлшгүй харгалзан үзэх олон хүчин зүйлийг судалж

нэмнэ.

Манай улсын хувьд “Хүн ам зүйн цонх үе” тохиож байгаа. Тодотгож хэлбэл, хөдөлмөрийн насныхан хүн амын дийлэнх хувийг эзэлж байгаа хэрэг. Тэгэхээр энэ онцлогийг түшиглэсэн тэр дундаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, “цонх үе”-ийг зохистой ашиглаж чадвал бүтээмж нэмэгдэж, хуримтлал зузаарч, эдийн засагт эерэг өөрчлөлтүүд авчирч чадна.

-Өнөөдрийн байдлаар төрөөс залуучуудыг дэмжих чиглэлээр ямар бодлого баримталж байгаа вэ?

-Манай улс төрөөс залуучуудыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр 1998-2005 онд “Залуучуудын үндэсний хөтөлбөр”, 2006-2015 онд “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлсэн. Гэхдээ одоогоор залуучуудад чиглэсэн цогц бодлого, хөтөлбөр алга.

Төрөөс залуучуудад үзүүлэх дэмжлэгийг хуульчилна

-Хуулийн төсөлд залуучуудыг хэрхэн дэмжихээр тусгасан байгаа вэ?

-Залуучуудыг халамжлах, халамж хүртээх гэхээсээ илүү хөдөлмөрлөх, бүтээх, хөгжүүлэхэд чиглэсэн, дэмжсэн хууль

гаргах юм. Монгол Улсын иргэн 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд энэ хууль үйлчилнэ. Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн байгууллага, залуучуудын байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтыг тусгасан байгаа.

Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийг байгуулна. Ингэснээрээ залуучууд шийдвэр гаргах түвшинд оролцох үүд нээгдэнэ. Төрөөс хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн чиглэлээр дэмжлэг үзүүлэх юм. Сургалтын хөтөлбөрт амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгана. Залуучуудыг хувиараа бизнес эрхлэх, гарааныхаа бизнес эхлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, харилцаатай иргэн болгож төлөвшүүлэхийн тулд цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучууд хүсэлтээрээ суралцаж болно.

-Залуучуудад орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх үү?

-Хуулийн төслийг боловсруулах хүрээнд 10 мянга орчим залуучуудын дунд түүвэр судалгаа хийхэд 10 залуу өрх тутмын нэг нь түрээсийн байранд амьдардаг гэж харуулсан байсан. Энэ хуулийг баталснаар залуу гэр бүлүүд хөнгөлөлттэй үнээр орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм. [ЗГМ]

ЭШЛЭЛ



-Эрх баригчид “АН-ын бодлогын алдааг засаж байна” гэдэг. Үүнтэй бид байр суурь нэгдэхгүй. Бидний харж буйгаар энэ бол бодлогын алдаа биш, бодлогын зөрүү юм. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, эдийн засгийн хүндрэлийг давна гэсэн бодлого баримталсан. Түүхий эдийн үнэ 2-3 дахин унасан үед 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бондоор Монголын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорьж, ажлын байр, цалингийн хэмжээг бууруулахгүй байхад анхаарсан.

Түүнчлэн АН өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд улсын төсвийг 6-7.6 их наяд төгрөгт хүргэсэн. Хоёрдугаарт, Хөгжлийн банкны зээл бүгд эзэн холбогдогчтой, эргэн төлөгдөх нөхцөлтэй, ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд зарцуулсан.

АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон baasan.b@zasag.co н-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

ТОВЧХОН

» **ЗАСГИЙН ГАЗАР**
Засгийн газрын ээлжит бус хуралдаан пүрэв гарагт болж, энэ оны төсвийн тодотголыг хэлэлцэв. Сангийн яамнаас боловсруулсан төсвийн тодотголтой Засгийн газрын гишүүд танилцаад, дэмжсэн байна. Хуралдааны үеэр гарсан саналуудыг төсвийн тодотголд тусгаж, УИХ-д өргөн мэдүүлэхээр боллоо.

» **ТОО**

23

Уяач. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ХҮИ жарны улаагчин гал тахиа жилийн босгон дээр зарлиг гаргаж, олон жил хурдан морины уяа сойлого тааруулж улсын хэмжээний наадмаас түрүү, айраг авсан 23 уяачид улсын цол хүртээлээ. Тодруулбал, Монгол Улсын тод манлай уяач цолоор тав, манлай уяачаар долоо, алдарт уяачаар 11 хүнийг тус тус өргөмжлөв.

» **УУЛЗАЛТ**

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт Итали улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Андрэа дэ Фелиппийг хүлээн авч уулзав. Тэд хар тамхи, авлига, албан тушаалын болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо. Улмаар иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэх гэрээ байгуулахаар ярилцжээ.

» **ШАГНАЛ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас энэ жилийн үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал “Төрийн гэрээг”-г “Говь” үйлдвэр, “Эрдэнэт хивс” компанид гардуулав. Энэхүү шагнал нь бизнесийн шинэ чиглэлийн хөгжилд хувь нэмэр оруулсан дэд бүтэц, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын салбарынханд жилд нэг удаа олгодог нэр хүндтэй шагнал юм.

» **МЭДЭГДЭЛ**

Ардчилсан намын нэр бүхий гишүүдийг санаатайгаар гүтгэж, нэр хүндэд нь халдах үйлдэл удаа дараа гаргаж байна хэмээн үзэж, УИХ-ын даргад тус тус намаас мэдэгдэл хүргүүлэхээр болжээ.

» **ШАЛГАЛТ**

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос Монголбанкны 2012-2016 оны үйл ажиллагааг дөрөвдүгээр сарын 30-ныг хүртэл шалгах Ажлын хэсэг байгуулжээ. Шалгалтаар үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн тогтвортой байдлыг хангах, “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-өөс эхлээд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн, хэвлэсэн мөнгөний хэмжээ болон алдагдалд зэрэгт дүгнэлт хийнэ.

» **ЧУУЛГАН**

Ардчилсан намын дэргэдэх Ардчилсан ахмадын холбооны IV чуулган болж, тус холбооны төргүүнээр Ш.Батбаярыг сонгоосон байна. Мөн энэ үеэр холбооныхоо дүрмийг хэлэлцэж, шинэчлэн баталжээ.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэсний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртөгтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтэртайментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, I хороо, Энхтайваны өргөн чөлөө, “Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co

“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч

Ц.Цэвээнхэрлэн



Нийтлэлчийн булан

Ирэх жилүүдэд ачааны хүндийг тэр л үүрнэ

Элгээрээ хэвтсэн

эдийн засгийг босгоод ирвэл түүхэнд нэр нь үлдэнэ

Л.Сугармаа
@sugarmaaZGM

Элгээрээ хэвтсэн эдийн засагтай Монгол Улсыг хөл дээр нь босгох хатуухан үүрэг энэ Засгийн газарт ногдож буйгаараа өмнөх үеийнхнээс онцлогтой. Олон жилийн турш архагшиж, бугшсан засаглалын хямрал, тогтолцооны гажуудлыг шидтэн л биш бол дөрөв байтугай дөчин жилийн хугацаанд ч зөв голдиролд нь оруулах хэцүү. Тоймлож хэлэхэд ч үг цөөдөм ийм хахирган хатуу уналтын үеийн улс орноо чирж явах хариуцлагатай хийгээд дарамттай үүрэг яах аргагүй төрийн эрхийг атгаж буй намын нуруун дээр унасан. Нөгөөтэйгүүр тулхтай, туршлагатай, төрийн жолоо атгаж чадах улс төрийн хүчин гэж үзээд дахин олгосон боломж, итгэлийг хөсөрдүүлэхгүйн тулд мэргэжлийн Засгийн газраа долоо бодож, нэг огтолсны дайтай тунгааж байгуулсан нь дамжиггүй.

Засгийн газрын ойрын үеийн зорилт бол эдийн засгийн хүндрэлийг аль болох ахархан хугацаанд давж, иргэдээ ажил орлоготой, амар тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх явдал юм. Мөн алхам бүрдээ хариуцлагатай байж, сонгуулийн амлалт, дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлэх чиглэлээр санаачилгатай, үр дүнтэй ажиллах цаг яг өмнө нь тулгарч байгаа. Тиймээс өмнөх Засгийн газруудаас илүү эрч хүчтэй, шинэлэг, зоримог, зөв бодлогоотой ажиллаж байж иргэдийн итгэлд эзэн байж чадна. Нөгөөтэйгүүр, ажлын үр дүн нь ард иргэдийн амьжиргаа хэр дээшлэв, нийгмийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэв гэдгээр хамгийн түрүүнд хэмжигдэнэ. Иймд энэ бүхний илрэл мэдээж ажлын эхлэлд бус хэдэн жилийн дараа мэдрэгдэх нь ойлгомжтой. Хүлээх л хэрэгтэй.

Манай улс төсвийн бодлогодоо он удаан жил "салхи" оруулаагүй, эдийн засгийн өөрчлөлтийг эхлүүлээгүй хугацаа алдсан нь хүндрэлийн жиг шалтгаан болсон гэдгийг эдийн засагчид онцолж буй. Ингэснээр гадаад, дотоод санхүүжилтийн хэрэгцээ, зээллэгийг улам нэмэгдүүлэх, гадаад өрийн хэмжээ өсөх, төсвийн тогтвортой байдал алдагдах, гадаад валютын албан нөөц шавхагдах, зээлийн чанар муудах зэрэг олон эрсдэлийг бий болгосон нь гагцхүү энэ Засгийн газрын хугацаанд засч залруулах "ял" болчихоод байгаа юм.

Иймээс л хурдан арга хэмжээ авч ОУВС-тай хөтөлбөр хэрэгжүүлэхээр ханцуй шамлаж буй. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаас харахад үүнээс өөр оновчтой сонголт байхгүй байгаагаар гадаад, дотоодын олон улсын санхүүгийн байгууллага болон мэргэшсэн эдийн засагчид хэлж байгаа. Гэхдээ Засгийн газрын хийж, хэрэгжүүлсэн ажил гэхээсээ илүүтэйгээр Монгол Улсын эдийн засгийн чадамж сайжрах, төсөв, санхүүгийн нэгдсэн удирдлагатай болохын зэрэгцээ сахилга батыг сахидаг болох зэрэг олон ач холбогдлыг дагуулах юм.

Дааж давшгүй энэ хүнд ажлын ард гарах үүргийг Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хүлээж буй. Тэрбээр үүргээ ч ухамсарлаж, үр дүнгээ эхнээс нь харуулж байгаа нь олзуурхуштай. Учир нь ОУВС-гийн хэрэгжүүлэх тусгай хөтөлбөрийн тухай мэдээтэй зэрэгцэн олон улсын хөрөнгийн бирж дээр Монголын тодотголтой бондуудын үнэ өсөж, төгрөгийг ноёрхсон ам.долларын ханш хүртэл шууд суларч эхэллээ.

Хэдийгээр намын дарга Ерөнхий сайд болдог бичигдээгүй хууль манай улс төрийн хүчнүүдэд үйлчилдэг ч энэ



ЗГМ

удаад мэргэжлийн Засгийн газар байгуулах мөрийн хөтөлбөрийнхөө дагуу мэргэшсэн эдийн засагчид бүрэлтгэх эрх мэдлийг атгуулсан юм. Түүний зангараг, туршлага, мэргэжил, чадлаараа илт тэргүүлсэн болоод л засгийн толгойд томилсон нь гарцаагүй. Тиймээс ч намынх нь зүгээс хямралтай үед мэргэжлийн эдийн засагчаар улс орноо төвхнүүлж авахаа мэдэгдэж байлаа.

Нүүрлэсэн хямралыг зөв бодлогоор гэтэлгэх үүрэг түүнд ногдож, хатуу цаг үетэй улаан нүүрээрээ тулсан Ерөнхий сайд гэдгээрээ тэр хамгийн "азгүй" хүн бас мөн. Нэн хүнд нөхцөл байдалтай, тураалд орсон эдийн засгийг хүлээн авч, ОУВС-тай хөтөлбөр хэрэгжүүлэх хэцүү үе тохиож буй энэ цаг үе түүний

өндөг шиг өөгүй нэрийг нь өөнтөглөхийг санаархагсдад сэдэв болж буй за. Ялангуяа албан тушаал горилж, ах дүүсийнх нь шахаа амжилтгүй болсон эрхмүүдийн "дотор хүн" нь гозойж босоод байгаа байх. Тиймээс л хүрч, халдаж чадахгүй ч гэсэн хөдөлгөж, ганхуулах тухай үг хааяа нэг сэмхэн шидчихээд ард нь нуугдаж суудаг хүмүүс байгаа.

Гэвч ил цагаан амбицлалгүй ул суурь, үндэслэлтэй төлөвлөж, хийж бүтээснээ хожим нь мэдрүүлж чаддаг түүний арга барил нийгэмд өндөрөөр үнэлэгдэж байгаа нь бат бэх хамгаалалт юм. Энэ хүн попчин, популист улстөрч биш гэдгийг өдгөө мэдлээ.

Бас ихэнхдээ анир чимээгүй талдаа "хатуу самар" болохоор

албан тушаал, ашиг сонирхол зэргээс холуур тойрч чаддаг нь холч ухааных нь илрэл. Ажлаа аваад удаагүй байхдаа л дүн шинжилгээ хийж мэдээлэхдээ "Хүнд худлаа хэлж, өөрсдийгөө хуурч хэрэггүй гэж үзсэн. Бид гадны хөрөнгө оруулагчдыг хуурч чадахгүй. Аливаа тоон мэдээллийг албаар засч, залруулснаас эдийн засагт учрах хохирол маш их. Засч, залруулсан мэдээллээр ажлаа хийгээд, үр дүнд хүрэхэд хэцүү. Бид өөрсдийгөө толинд хараад, царай муутай байхаар нь толио хагалчихаж болохгүй." хэмээсэн хэдхэн үг нь нотолно.

Энэ нь ч намдаа байтугай яах аргагүй төрд хэрэгтэй "зайран" мөнөөс мөн гэдгийг өдөр хоногоор мэдрүүлж буй. Ирэх

жилүүдэд ачааны хүндийг тэр л үүрнэ. Дөрөв хөрвөсөн ага ачааны хүндийг, дөч эргэсэн эр ажлын хүндийг даана гэж манай ард түмэн мэргэн сургажээ. Түүнд монголчууд ихээхэн хариуцлага хүлээлгэсэн өдрүүд үргэлжлэх нь.

Хөрөнгө мөнгө хомсдож, гар хүлээтэй мэт буцлам халуун үйл явдлууд өрнөсөн ийм хэцүү үед эдийн засагч сэтгэлгээгээр ажиллан маш богино хугацаанд ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах гарц олж, хэдхэн сарын дотор ажил хэрэг болгож чадлаа. Урд өмнө нь тохиож байгаагүй уналтад орсон ийм хүнд үед Засгийн газрыг толгойлон ажиллаж байгаа нь азгүй. Гэвч маргаж, мэтгэлцэлгүй зөвхөн урагшаа харж зоригтой хөдлөхгүй бол цаг

алдаж, алгуурлан алмайрч огт болохгүй түүхэн мөчтэй уралдан ажиллаж байна, тэр.

Дөрвөн жилийн дараах өнөөдөр хоёрын хооронд тэнгэр газар, тэмээ ямаа мэт ялгаа гарч, эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд огцом дээшлэх муурийг урьдчилан мэдэж байгаа нь лавтай. Энэ Засгийн газрын бүрэн эрхийн тогтвортой байдлыг хангаж удахгүй "сайн" дүн тавих цагийг хүлээе.

Харин туйлдаж ядарсан Монгол Улсыг сэхээн амьдруулж, элгээрээ хэвтсэн эдийн засгийг босгоод ирвэл түүхэнд нэр нь мөнхрөх Ерөнхий сайд болох учиртай. Ямар ч гэсэн хариуцлагыг нуруунд нь үүрүүлж, цаг хугацаа, боломжоор хангах нь чухал гэж мэргэн ард үзэж буй. [ЗГМ]

АВСТРИЙН АЛДАРТ JOY ХАМТЛАГ МОНГОЛЫН ТАЙЗНАА

BACK TO THE 80 & 90'S DISCO CROCUS

JOY

Мартын

БАЯРЫГ ТОХИОЛДУУЛАН 80, 90 ОНЫ DISCO PARTY

CROCUS EVENT HALL

ШАР АЙРАГ ХАМТЛАГИЙН SMOKIE КОВЕР ТОГЛОЛТ

2017.03.07-ны 19:00 цагт

www.crocus.mn | facebook.com/CrocusEventHall | Утас: 77110101, 80044411, 80101144

Сурталчилгаа



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

УИХ-ын намрын чуулганаар “Эрдэнэт үйлдвэр” болон “Монголросцветмет” компаниудын ОХУ-ын “Ростех” корпорацийн эзэмшиж байсан 49 хувийн энгийн хувьцааг “Монголын зэс корпораци” компани хууль ёсоор худалдан авсан Хэлцлийн талаар тогтоол гаргасантай холбогдуулан тус компанийн зүгээс дараах албан ёсны байр суурийг илэрхийлж байна.

Монгол Улсын Ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойшхи түүхэнд анх удаа хууль тогтоох дээд байгууллага нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хувийн өмчийг нийгэмчлэх шийдвэр гаргасан явдалд манай компани гүнээ харамсаж байна.

Энэхүү шийдвэр нь Монгол Улсын сонгосон хөгжлийн зам, чөлөөт зах зээл, шүүх засаглалын суурь зарчим, олон улсад Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг улс төрийн зорилгоор, бүдүүлгээр зөрчсөн асуудал боллоо. Хэдхэн хүний явцуу эрх ашиг, хувийн сонирхол биелээгүйгээс бүх зүйлийг харлуулж, түүхэн ховор боломжийг албан тушаал, эрх мэдлээ ашиглан улс төржүүлэн луйвар хэмээн зарлаж байгаа нь хөрш орнууд төдийгүй олон улсад Монгол Улсын нэр хүндийг сэвтүүлсэн үйлдэл гэж үзэж байна.

УИХ-ын тогтоолын үндэс болсон Хууль Зүйн Байнгын хорооны дүгнэлт нь хэт нэг талыг барьсан, хууль бусаар мэдээлэл цуглуулсан, тоо баримт бодит мэдээллийг зориуд мушгин гуйвуулж УИХ-ын гишүүдэд танилцуулан шийдвэр гаргуулсан нь цаашид Монгол Улсад ноцтой сөрөг үр дагавар авчраад байна.

Хуулиар хамгаалсан хувийн өмчийн эрхэнд халдсан, улстөржүүлсэн аливаа хууль бус шийдвэрийг “Монголын зэс корпораци” компани хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд өөрсдийн хууль ёсны эрх ашгаа хамгаалах асуудлаар тууштай тэмцэнэ. Манай компанийн хийсэн хэлцэл нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, олон улсын хэлцлийг ямар ч байдлаар зөрчсөн зүйл байхгүй гэдгийг удаа дараа хариуцлагатайгаар мэдэгдэж ирсэн.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК Монгол улсдаа үр ашгаа өгдөг, олон улсад өрсөлдөхүйц компанийн засаглал, үйл ажиллагаа, ажилтан төвтэй аж ахуйн нэгж байх ёстой гэсэн зарчмыг бид баримталж ирсэн. Гадаад улсын эзэмшиж байсан өмчийг Монголдоо авчирсан түүхэн хэлцэлтэй холбоотой асуудлаар олон нийтэд бодит мэдээллийг хүргэх, хэн нэгэн эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн улс төр, хувийн ашиг хонжоо хайсан сэдэв болгохгүйн төлөө хариуцлагатайгаар ажиллах болно.

2017 оны 2-р сарын 24
Улаанбаатар хот

Нийгэм

Шөнийн хөнгөлөлтийг
нөхөж тооцно

Б.Ганбаяр/ЗГМ

Эрчим хүчний шөнийн хэрэглээ 15.9 хувиар өсчээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд багтаагүй 16 хорооны өрхүүдэд цахилгааны шөнийн хөнгөлөлтийг нөхөж

тооцохоор болсон талаар Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоол гарсан байна.

Ингэснээр энэ оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн гэр хорооллын айл, өрхийн цахилгааны шөнийн хэрэглээний 700 мВт хүртэлх эрчим хүчийг тэглэх шийдвэр нийслэлийн гэр хорооллын бүх өрхөд адил үйлчлэхээр боллоо. Нийслэлийн хэмжээнд гэр хорооллын 112 мянган өрхийг цахилгаанаар хангадаг “Улаанбаатар цахилгаан

түгээх сүлжээ” хувьцаат компанийн үзүүлдэд буй шөнийн хөнгөлөлт 700 орчим сая төгрөгт хүрчээ. Үүнд 700 мВт хүртэлх эрчим хүчний хэрэглээний үнийг 100, түүнээс илүү гарсныг нь 50 хувь хөнгөлж тооцсон дүн багтаж буй.

Агаарын бохирдлыг бууруулах үүднээс гэр хорооллын өрхүүдэд цахилгаан халаагуураар дулаанаа шийдэх бололцоо олгосон уг шийдвэр ийнхүү бодитой хэрэгжиж байна. УЦТС ХК-

ийн нэгдүгээр сард борлуулсан шөнийн эрчим хүч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6 хувиар өссөнийг албаны эх сурвалж хэлэв. Уг өсөлтийн талаас илүү хувийг гэр хорооллын өрхүүд бүрдүүлсэн бол орон сууцныхны цахилгааны шөнийн хэрэглээ өссөн хувиар л өссөн байна. Түүнчлэн цахилгааны шөнийн борлуулалтын орлого ч дурдсан хугацаанд 15.8 хувиар өсөж, 248.9 сая төгрөг болжээ. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Өрхүүдийн өдрийн хэрэглээ нэмэгдсэн



Ирэх дөрөвдүгээр сарын 1-н хүртэл хэрэгжих хөнгөлөлт иргэдэд төдийлэн мэдрэгдэхгүй байгаа талаар олон нийт ярьж буй. Тиймээс энэ талаар УЦТСХК-ийн Борлуулалтын бодлогын хэлтсийн дарга Ц.Энхсайханаас дараах тодруулгыг авлаа.

-Гэр хорооллын өрхийн цахилгааны шөнийн хэрэглээ тэглэсэн. Гэвч цахилгааны төлбөр нь харьцангуй өндөр гарсан, хэмнэлт мэдэгдэхгүй байгаа тухай хүмүүс их гомдоллож байна. Үүнийг юу гэж үзэж байна вэ?

-Шөнийн хэрэглээний хязгаар нь 700 кВт. Үүнийг иргэд бүрэн гүйцэд ойлгоогүйгээс эрчим хүчээ хэт хэрэглээд байна. Ялангуяа айл өрхүүдийн эрчим хүчний өдрийн хэрэглээ нь ихэссэн. Гэтэл энэ нь хэрэглэгчдэд манай байгууллагын алдаатай үйл ажиллагаа юм шиг харагдаж байна. Яг үнэндээ манай эрчим хүчний дэд станцууд, борлуулалт бүгд хяналттай.

-Бидэнд байгаа мэдээллээр эрчим хүчний сарын дундаж хэрэглээний төлбөр нь 50 мянган төгрөг гардаг айлынх нэгдүгээр сард 623 мянга гарсан байна. Хэрэглэгчийн цахилгааны код нь ч бий. Энэ талаар ямар тайлбар огох вэ?

-Кодоор нь шалгаж үзэхэд Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны оршин суугчийн цахилгааны төлбөр 623 мянган төгрөг гарсан байсан. Бид газар дээр нь хоорондоо маргалдсанаас болж нэгнийгээ зодож гэмтээсэн дуудлага нэмэгддэг аж. Тиймээс хугацаа нь дууссан бүтээгдэхүүн авахгүй байх, зориулалтаар нь хадгалахыг Яаралтай түргэн тусламжийн төвийн Их эмч Л.Бямбацогт санууллаа. [ЗГМ]

-Танай системд бүртгэгдсэнээр өмнөх сарын заалт нь хэд байсан бэ?

-Нэгдүгээр сарын 19-нд бичихэд тоолуурын заалт 6100 байсан.

-Үүний шалтгаан нь юутай холбоотой байж болох вэ?

-Эцсийн дүгнэлт гараагүй болохоор шалтгааныг хэлэхэд эрт байна. Хуримтлагдсан бичилт үүссэн, эсвэл тоолуур дээр гэмтэл гарч, заалт үеэрсэн байхыг үгүйсгэхгүй.

-Бас нэг өрх байна. Төлбөр нь сард дунджаар 45 мянган төгрөг гардаг. Нэгдүгээр сард үүнээс гурав дахин өндөр төлбөр гарсан гэсэн?

-Тийм ээ. Толгойтод байрлалтай, СХД-ийн нэгдүгээр хорооны өрх. Энэ хэрэглэгчийн хувьд өдрийн хэрэглээ сарын дунджаас

өндөр буюу 810 кВт гарсан байна. Төлбөр нь 84,440 төгрөг. Шөнийн хэрэглээ нь 390 кВт буюу 18,026 төгрөг гарсан учраас хөнгөлөлтдөө бүрэн хамрагдсан. Бусад суурь хураамж, татварын зэрэг төлбөртэй нийлээд 106 мянган төгрөг төлсөн байна.

-Иргэд эрчим хүчний хэрэглээгээ хэрхэн хянах вэ?

-Уг нь хэрэглээгээ хянаад явахад хэцүү биш шүү дээ. Ерөнхийдөө орон сууцанд бүрэн автомат угаалгын машин, богино долгионы зуухны цахилгааны хэрэглээ өндөр гардаг. 24 цаг тасралтгүй ажилладаг хөргөгч сард 30 кВт, мөн улайсдаг ламп гурвыг өдөр бүр хэрэглэдэг гэж тооцвол нэг өрх дунджаар 36 кВт-ийн эрчим хүч зарцуулж байгаа. Энэ мэтээр цахилгаан зуух, тоос сорогч, хөлдөөгч зэргийнхээ хэрэглээг тооцоод, нэгж үнээр нь бодоод гаргачихаж болно.

-Өдөр, шөнийн хэрэглээний үнийн зөрүү хэр их вэ?

-Тухайлбал, 1.5 кВт-ийн шарах шүүгээг өдөрт хоёр цаг ажиллуулдаг гэж үзвэл тухайн өдрийн хэрэглээ гурван кВт болно. Үүнийг өдрийн хэрэглээний тарифаар тооцоход сард 9,387, жилд 114,208 төгрөгийн эрчим хүч хэрэглэж байна гэсэн үг. Тэгвэл шөнийн тарифаар тооцвол сард 6,939 төгрөг гарч байна. Ингээд тооцоход шөнийн хэрэглээнд өдрийнхөөс 2500 орчим төгрөг л хэмнэж байна, зөвхөн богино долгионы зуухны хувьд шүү дээ.

-Хэрэглэгчдийн дунд электрон тоолуур нь механикаасаа их гүйдэг гэж яриа бий. Энэ ямар учиртай юм бол?

-Электрон тоолуур бол нарийвчлал өндөртэй. Гар утсаа цэнэглэхэд электрон тоолуурын заалт гүйж байдаг бол механик тоолдоггүй.

-Тэгэхээр зөрүү нь хэр зэрэг гарна гэсэн үг вэ?

-Уг нь бол нэмэх, хасах хоёр хувь. Тийм өндөр биш л дээ. Механик тоолуурыг социализмын үеэс л хэрэглэж байгаа. Үүн дээр гаднаас тохируулга хийдэг. Электрон тоолуурын хувьд ийм боломжгүй тул хэрэглээг үнэн зөв гаргадаг. Хэрэглэгчдийн хардаад байдаг учир нь ердөө л энэ. Гэтэл үнэн хэрэгтээ ТВ үзээгүй байсан ч тогноос нь бүрэн салгаагүй л бол таны тоолуурын заалт гүйж байдаг.

-Иргэдийн өдрийн хэрэглээ замбараагүй байсан талаар та дээр хэлсэн. Өдрийн хэрэглээ нь хэр өссөн бэ?

-Өдрийн хэрэглээг одоохондоо тухайлж гаргаагүй. Мэдээж өмнөх онтой харьцуулахад өссөн. Иргэд хэрэглээндээ л хяналт сайн тавих хэрэгтэй. Гэр хороололд бол цахилгаан халаагуур, халуун тогоо зэрэг нь эрчим хүчний хэрэглээний дийлэнхийг бүрдүүлдэг. Угаалгын машин бас багтана. [ЗГМ]

АНХААРУУЛГА

Гэрээ эзэнгүй орхихдоо цахилгаан хэрэгслээ шалгаарай

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Сар шинийн баярын өдрүүдэд иргэдийн анхаарал болгоомжгүй үйлдлээс болж бэртэж гэмтэх, гал түймэр гарах, архи, хоолны хордлогонд орох явдал ихэсдэг. Өнгөрсөн жилд гэхэд иргэдийн анхаарал болгоомжгүй үйлдлээс болж гал түймрийн 28 дуудлага

Нийслэлийн онцгой байдлын газарт ирж байжээ. Харин Гэмтэл согог судлалын үндэсний төвд 100 гаруй мянган хүн осол гэмтэлд өртсөний 16 хувь нь зам тээврийн ослоос болсон байна. Тиймээс баяр тохиолдуулан олон хоног амрах учир албан байгууллага, аж ахуйн нэгжүүд байнгын эргүүл, жижүүрийг ажиллуулах хэрэгтэй.

Хамгийн чухал нь хөгжлийн

бэрхшээлтэй болон насанд хүрээгүй хүүхдийг харгалзан асрах хүнгүй үлдэхгүй, гэрээсээ гарахдаа цахилгаан хэрэгслээ сайтар шалгах шаардлагатай гэдгийг Нийслэлийн Онцгой байдлын газрын дэд дарга Д.Эрдэнэбаатар хэлсэн юм. Иймээс эвдрэл гэмтэлгүй зориулалтын цахилгаан хэрэгслийг ашиглаж гэрээ эзэнгүй үлдэхдээ сайтар шалгахыг анхааруулж

байна.

Баярын үеэр түргэн тусламжийн төвд архи, хоолны хордлого, согтуу үедээ хоорондоо маргалдсанаас болж нэгнийгээ зодож гэмтээсэн дуудлага нэмэгддэг аж. Тиймээс хугацаа нь дууссан бүтээгдэхүүн авахгүй байх, зориулалтаар нь хадгалахыг Яаралтай түргэн тусламжийн төвийн Их эмч Л.Бямбацогт санууллаа. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.02.24

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт автомашины дугуй нийлүүлэгчийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: УСУГ-БМ-2017-03-33

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос автомашины дугуй нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000 /тавин мянган/** төгрөгийг Ус сувгийн удирдах газрын **Хас банк 5000075928** дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд 2015, 2016 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгөөс дээш байх.

Тендерийн хамт 1,800,000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 05 дугаар сарын 08-ний өдрийг дуустал.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 00 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлж ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157019-223, 88119507

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017 он 02 сар 24 өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Төрөл бүрийн хиам нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: ЭЗГ-03/2017

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Төрөл бүрийн хиам нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгийг **Хаан банк 5038008126** тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2016 оны борлуулалт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендер санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт.

Сүүлийн 1 жил /2016 он/

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: 2016 он /ноглох баримтын хамт лавлагаа авах тодорхой утас, хаяг/

Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: Шаардлагатай

Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцно

Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор тендерийн баталгаа ирүүлж болно.

Тендерийг **2017 оны 03 дүгээр сарын 27-ны 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 03 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357 Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017 он 02 сар 24 өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Тахианы төрөл бүрийн мах нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: ЭЗГ-04/2017

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Тахианы төрөл бүрийн мах нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгийг **Хаан банк 5038008126** тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2016 оны борлуулалт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2016 оныг ирүүлэх /дүгнэлтийн хамт/

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: 2016 он нотлох баримтын хамт **Дотоодын давуу эрх:** Тооцно

Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор тендерийн баталгаа ирүүлж болно.

Тендерийг **2017 оны 03 дүгээр сарын 27-ны 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 03 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357 Факс 7018-1309 7000-1357

Кино зах зээл

Мэрил Стрийн 20 дахь удаагаа нэр дэвшилээ

Б.Баярмаа
@bayarmaaZGM

“Оскар”-ын наадам болоход хуруу дарам цөөхөн хоног үлдлээ. Энэ ням гарагт “Академийн шагнал гардуулах ёслол”-оос хэн нь “Алтан хүн” авах талаар ажиглагчид таамаг дэвшүүлээд байна. Эдгээрээс шилдэг эрэгтэй болон эмэгтэй дүрийн шагналд хамгийн олон “санал” авсан уран бүтээлчдийн талаар хүргэе.

“ГҮЙЦЭД БОЛОВСОРСОН” ЭММА СТОУН

Алдарт “Титаник” киноны түүхэн амжилтыг эвдэж, “Оскар 2017” наадамд хамгийн олон төрөлд нэр дэвшсэн кино бол “La la land”. “Титаник” 11 төрөлд нэр дэвшсэн бол тус кино 14-н “Оскар”-ын төлөө өрсөлдөж байна. Уг бүтээлийг ийм амжилтад хүрэхэд нөлөөлсөн хүнээр жүжигчин Эмма Стоуныг нэрлэж буй.

Эмма гэнэт олны танил болоогүй. Дөрвөн настайдаа анхныхаа жүжигт тоглож, өсвөр насандаа олон нийтэд танигдсан түүнийг одоо л “боловсорч гүйцсэн” гэж үнэлэв. Багаасаа дуу хөгжимд авьяастай, бродвей жүжигт дурладаг байжээ. Тэрбээр 2015 онд “Forbes” сэтгүүлээс гаргасан хамгийн өндөр орлоготой эмэгтэй жүжигчдийн 16-д жагссан юм.

Өдгөө 31 настай жүжигчин бүсгүй 2014 онд “Хүн шувуу” киноны дүрээрээ “Оскар”-ын шилдэг эмэгтэй туслах дүрд нэр дэвшсэн ч шагнал гардаг чадаагүй. Харин “La la land” мюзикл түүнд шагналын хур буулгаж эхэллээ. Эмма “Алтан бөмбөрцөг” болон Английн



Шилдгүүдийн тулаан



кино академийн наадмаас шилдэг эмэгтэй дүрийн шагнал аваад буй. “Оскар 2017”-д ч энэ амжилтаа давтаж магадгүй нь.

МЯТРАШГҮЙ МЭРИЛ СТРИЙП

“Оскар”-ын наадмын түүхэнд хамгийн олон удаа нэр дэвшсэн жүжигчнээр Мэрил Стрийп тодрод байна. Тэрбээр хамгийн

анх 38 жилийн өмнө “Бугын анчин” киноны гол дүрээр нэр дэвшиж байв. Харин өнөөдөр “Florence Foster Jenkins” киноны дуурийн дуучин болох хүсэлтэй баян эмэгтэйн дүрээр 20 дахь удаагаа нэр дэвшиж байгаа юм. Тэрбээр нийт 69 кинонд дүр бүтээж, 11 драмын жүжигт тогложээ.

61 настай Мэрил Стрийпад

гурван “Алтан хүн” байдаг. Тэрбээр 1980, 1983, 2012 онд “Оскар”-ын наадмаас шилдэг эмэгтэй гол дүрийн шагнал авч байсан. Мөн “Алтан бөмбөрцөг” наадмын 30 төрөлд нэр дэвшиж, наймыг нь авч чадсан.

Тэрбээр өнгөрсөн сард болсон “Алтан бөмбөрцөг” наадмын тайзнаас “Холливуудыг цагаачид, гаднын иргэд бүтээсэн.

Хэрвээ цагаачлалыг хоригловол хөлбөмбөгөөс өөр үзэх зүйлгүй болно” гэж АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп шүүмжилсэн. Энэ удаад “Оскар”-ын тайзнаас шагнал гардвал чухам юу хэлэх бол гэдэг нь сонирхолтой.

ГУРАВ ДАХИА ХҮЛЭЭЖ БҮЙ ДЕНЗЕЛ ВАШИНГТОН Холливуудын ахмад жүжигч-

дийн нэг Дензел Вашингтоныг энэ жил гурав дахь удаагаа “Оскар” авна гэж IMDb сайтын санал асуулгад оролцогчид үнэлжээ. Тэрбээр 1989 онд “Ялалт”, 2001 онд “Бэлтгэлийн өдөр” кинонд тоглож, эрэгтэй шилдэг жүжигчнээр тодорч байсан. Харин энэ удаад өөрөө найруулагчаар нь ажилласан “Хашаа” киноны гол дүрээр нэр дэвшилээ.

Бэйсболын тамирчин болох мөрөөдөлдөө хүрч чадаагүй Трой (Дензел Вашингтон) хүүгээ хөлбөмбөг тоглохыг эсэргүүцнэ. Өнгөт арьстайгаасаа болж сэтгэлийн шархтай үлдэх вий гэж айх боловч хүү нь үнэхээр амжилтад хүрч магадгүй гэсэн итгэлийн “гал” түүнд бий. Өөрийнхөө туулсан амьдралыг хүүдээ үзүүлэхийг хүсээгүй эцгийн дүрийг чадварлаг бүтээсэн гэж түүнийг үнэлж байна.

АХЫНХАА АРААС “НЭХЭХ” КЭЙСИ АФФЛЕК

Жүжигчин Бен Аффлект “Оскар”-ын хоёр цом байдаг. Харин гурван насны зөрүүтэй дүү Кэйси Аффлек нь энэ жил ахынхаа амжилтыг давтаж магадгүй. Тэрбээр “Manchester by the sea” киноны Лий Чандлерийн дүрээр шилдэг эрэгтэй жүжигчний төрөлд нэр дэвшээд буй. Мөн уг дүрээрээ “Алтан бөмбөрцөг” наадмаас шагнал хүртсэн нь таамгийн эхэнд бичигдэхэд нөлөөлсөн юм.

Кэйси кино урлагт шинэ хүн биш. Тэрбээр ахынхаа адил кино урлагт олон жил зүтгэж байгаа нэгэн. Нийт 33 кинонд дүр бүтээсэн бөгөөд 2007 онд “Оскар”-ын шилдэг эрэгтэй туслах дүрд нэр дэвшиж байсан юм. Кэйси жүжигчнээс гадна найруулагч, зохиолч. Тэрбээр нэг кинонд найруулагчаар ажиллаж, хоёр киноны зохиолч бичээд байгаа юм. Мөн энэ онд өөрийнхөө бичсэн зохиолыг найруулж “Миний амьдралын гэгээ” нэртэй кино хийхээр төлөвлөжээ.[37M]

СОНИРХУУЛАХАД

Дээд амжилтууд

89 жилийн түүхтэй “Оскар”-ын наадмын содон амжилтуудаас хүргэж байна.

- Хамгийн олон төрөлд нэр дэвшсэн киноны жагсаалтыг 1950 онд гарсан “All about Eve” кино тэргүүлдэг. Тус кино 16 төрөлд нэр дэвшиж, зургааг нь авч чаджээ.
- Уолт Дисней хамгийн олон буюу 22 удаа “Оскар”-ын шагнал гардсан байдаг.
- Тус наадмын түүхэнд

хамгийн урт киногоор долоон цаг 47 минут үргэлжилдэг “O.J.: Made in America” тодорчээ.

- Энэ жил “Moon light” киноны дүрээр нэр дэвшиж буй Наоми Харрис ердөө гурван өдрийн турш зураг авалтад оролцжээ.
- Татум Онил 1974 онд 10 настайдаа “Цаасан сар” киноны дүрээрээ “Оскар”-ын шагнал хүртсэн хамгийн залуу жүжигчин

болсон юм.

- “Загалмайлсан эцэг” киноны нэг болон хоёр дугаар ангид гол дүрд тоглосон жүжигчин Марлон Брандо, Роберт Де Ниро нар хоёул “Оскар”-ын эзэн болжээ.
- Клинт Иствүүд 74 настайдаа “Сая долларын бүсгүй” (2004) киногоор “Оскар” авсан хамгийн ахмад жүжигчнээр тодорчээ.



UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна
Утас: 96481125, 99087992
- Автомашинны хагарч цуурсан шил наагч зарна.
Хүргэлттэй. Үнэ: 35000 төгрөг
Утас: 99679962
- Шинэ дугуйнууд зарна.
Үнэ: 100.000 төгрөг
Утас: 88006734
- Аgiom шинэ дугуйнууд зарна
Утас: 99101688 /Үнэ тохирно/
- 2009 оны “FX35” хямд зарна.
Үнэ: 25 сая төгрөг
Утас: 99111468
- “G500” зарна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна.
Утас: 99993434
- 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай “Grand mark 2” яаралтай зарна. Үнэ 5 сая төгрөг. Утас: 96651794
- 2009 оны “HUMMER H2” зарна. Утас: 91777877
- 2008 оны “LX570” зарна. Үнэ: 60 сая төгрөг
Утас: 99111468
- “Full option A8” зарна.
Утас: 99995108

КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна.
Угсралт тохиргоо үнэгүй.
Утас: 75752020
- Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000 төгрөг
Утас: 88998138
- Ipad-1 wifi 16gb зарна.
Утас: 99002508
- Төмөр гадаргуутай 2TB багтаамжтай зөөврийн hard диск зарна.
Утас: 98886655
- “Sony Vaio core i5” notebook хямд зарна.
Үнэ: 500.000 төгрөг
Утас: 88102740
- Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock
Утас: 88771767
- “Kogy notebook shop” бүх төрлийн used нөтбүүк, таблет худалдааж байна. Үнийн хувьд хамгийн хямд, өргөн сонголттой. Өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд ажиллана. Утас: 89997986

ҮЛ ХӨДЛӨХ

- Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. 2011 онд ашиглалтанд орсон төмөр бетон суурь, төмөр бөс бетон, 38-ийн дан тоосго, гадна талд хөөсөөр дулаалсан 200м2, 2давхар, машины гражтай, 380в цахилгаантай, цахилгаанаар бүрэн халдаг, 96м гүнээс худагийн ус гарсан цэвэр устай, халуун устай, цэвэр бохироо бүрэн шийдсэн өвөл зуны дулаахан чанартай сайн барьсан. - Нийт 6 өрөө, гал тогоо, зочны өрөө, 2 ариун цэврийн өрөөтэй, гал тогоо 00-д халуун устай, вакум цонх, паркетин шалтай дотор интерьер засал сайн.
Утас: 99289768
- 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. Утас: 88192130
- Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494
- Хүүхдийн Паркийн замын урд зам дагуу төвийн шугамд холбогдох боломжтой 300м2. -22-н товчоо тойргийн хажууд зам дагуу Iга 380 тогтой блокон хашаатай газар.
-Хонхорт зам дагуу 9200м2 төвийн шугамд холбогдох боломжтой, худалдааны төв, шатхуун түүгээрүүр, аж ахуй, агуулах, хөнгөн үйлдвэр зориулалтаар ашиглах боломжтой газар.
-Эмээлтэд 5га газар.
Утас: 99289768
- Сансарын тунелд 1 давхарын гал тогоо тусдаа 3 өрөө байр зарна. Утас: 99760217, 99101271

НОМ, ХЭВЛЭЛ

- Бүх төрлийн ном хэвлэл худалдааж байна.
Утас: 99144154
- Хуучин номнууд зарна.
Утас: 94640105
- Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearson's international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна.
Утас: 99153637
- Ээж ба хүүхэд ном зарна.
Утас: 99089401
- Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна.
Утас: 99625921
- Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312
- Монголын залуучуудад хүн төрөлхтний хөгжлийн их алхаатай хөл нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбараар илэрхийлж чадсан “Монгол хүний хөгжил төлөвшлийн ДЭЭД УХААН” ном уншигчдын гэр дээр очиж байна.
Утас: 98111029
- Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зуриул ном зарна.
Үнэ: 30.500

ЦАХИЛГААН БАРАА

- Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 AAA батареи (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C)
Утас: 88512938, 96012938
- Модерн загварын ханын цаг (45-55cm) худалдана.
Утас: 96012938, 88512938
- USB гагнуурын алх. Эгшин зуур хална, хөрнө. 480 C градус хүртэл хална.
Утас: 96012938

ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ үзэгт орохыг анхаарна уу.



Авто

Ford F-Series өнгөрсөн онд хамгийн их зарагдсан машинаар тодров

Г.Очирбат
@ochirbatZGM

Их Британийн судалгааны "JATO Dynamics" компани 2016 оны дэлхийн автомашины борлуулалтын талаарх сонирхолтой статистикийг танилцууллаа. Автомашины голлох зах зээлд



Дэлхийн автомашины борлуулалт 5.6 хувиар өсчээ

багтдаг дэлхийн 52 улсад хийсэн уг судалгаа өнгөрсөн онд дэлхий даяар зарагдсан шинэ хөнгөн тэрэг, вэн буюу furgon машинуудыг хамарч байна.

Судалгааны дүнг үзвэл, дэлхийн хэмжээнд 2016 онд автомашины борлуулалт жилийн өмнөхөөс 5.6 хувиар өсөж, 84.24 сая ширхэгт хүрчээ. Тус компанийн мэргэжилтнүүдийн тооцоогоор зах зээлд БНХАУ урьдын адил тэргүүлж, өнгөрсөн онд 25.5 сая машин борлуулсан нь жилийн өмнөхөөс даруй 14.2 хувиар өссөн үзүүлэлт юм. АНУ удаах байранд орж, 17.6 сая машин заржээ.

Энэхүү үзүүлэлтээр Азид БНХАУ-ын дараа, дэлхийд гуравдугаарт орж буй Япон 4.8 сая ширхэг автомашин борлуулсан амжилттай. Харин Европ тивд тэргүүлж, дэлхийд дөрөвдүгээрт орсон ХБНГУ-д

3.6 сая автомашин зарагджээ. Жагсаалтын 13 дугаар байранд орсон ОХУ-д борлуулалт 2.8 хувиар буурсан дүнтэй байгаа юм. Хөгжиж буй зах зээлээс Энэтхэг улс дэлхийд тавдугаарт орж, 3.3 сая автомашин борлуулсан нь жилийн өмнөхөөс 8.4 хувиар өссөн үзүүлэлт болов.

Борлуулалтаараа дөрөвт орж буй машин нь БНХАУ-ын Wuling Hongguang

Автомашин үйлдвэрлэгчдийг брэндээр нь ангилах тохиолдолд эхний гурван байрт Toyota (7.2 сая), Volkswagen (6.1 сая), Ford (7.2 сая) орлоо. Toyota брэндийн

АНУ, Хятад дахь борлуулалт өнгөрсөн онд багассан ч Индонез, Мексикт худалдан авагчийн тоо өссөн нь тэргүүн байраа хадгалж үлдэх нөхцөл болов. Audi, Porsche, Skoda, Bentley зэрэг харьяа брэндийг нь хасах тохиолдолд Volkswagen тэргүүн байрт бус, хоёрт орж байна. Volkswagen-ий хувьд өнгөрсөн онд утааны ялгарлын хэрэгт холбогдсон ч борлуулалт нь 2.8 хувиар өсчээ.

Удаах байруудад Honda (4.6 сая), Nissan (4.5 сая), Hyundai (4.1 сая) гэсэн гурван брэнд оров. Эдгээр брэндийн борлуулалт өссөн нь шинээр гаргасан SUV загварынх нь ач хэмээн судалгаанд тайлбарлажээ.

Харин тодорхой загвараар нь тооцвол Ford F-Series машин (зураг дээр) өнгөрсөн онд АНУ-ын зах зээлд 986 мянган ширхэг зарагдсан амжилтаар дэлхийд

хамгийн борлуулалттай загвар болов. F цувралын машины борлуулалт жилийн өмнөхөөс 7.7 хувиар өссөн дүнтэй. Хоёрдугаар байрт Toyota Corolla загвар дэлхий даяар 952 мянган ширхэг зарагдсан амжилтаар орж байна. Гэхдээ уг машины борлуулалт ердөө 0.9 хувь өсчээ. Гуравт 859 мянган ширхэг зарагдсан Volkswagen Golf/GTI загвар орлоо.

Сонирхолтой нь, дэлхийд борлуулалтаараа дөрөвт орж буй машин нь БНХАУ-ын үйлдвэрлэгчийн Wuling Hongguang (847 мянган ширхэг) хэмээх төдийлэн танил бус загвар байгаа юм. Тавдугаар байрт орсон Nissan X-Trail (Rogue) загвар дэлхий даяар 766 мянган ширхэг зарагджээ. Удаах байруудад Hyundai Avante (Elantra, I35), Ford Focus, Honda HR-V (XR-V, Vezel), Honda CR-V, Toyota RAV-4, Honda Civic зэрэг загвар орлоо. [31M]

ЗГМ: ТОДРУУЛГА

Монгол Улсын жолооны үнэмлэхийг 73 оронд ашиглаж болно

Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн Я.Соронзонболдоос жолооны үнэмлэхний талаар зарим зүйлийг тодрууллаа.

-Олон улсад ашиглах боломжтой нэгдсэн жолооны үнэмлэх гэж байдаг уу?

-Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийг 1968 онд баталсан. Энэ конвенцид нэгдсэн орны иргэд өөрийн улсын үнэмлэхээр бусад оронд автомашин жолоодох эрхтэй байдаг. Эдгээр орны замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ нь нэг стандарттай. Гэхдээ зөвхөн нэг жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд хугацаа нь дууссаны дараа тухайн орны үнэмлэх авах шаардлагатай. Венийн конвенцид 2014 онд Вьетнам улс нэгдэн орсноор 73 орны бүрэлдэхүүнтэй болсон. Харин манай улс 1997 онд нэгдсэн байдаг.

-Венийн конвенцид багтдаг орнууд дотор монголчууд олноороо амьдардаг ямар улс байдаг вэ?

-Чех, Нидерланд, Швед, Австри, Турк зэрэг орон бий.

-Манай хөрш орнууд багтдаг уу?

-ОХУ, БНХАУ энэ жагсаалтад ордоггүй. Мөн АНУ, БНСУ зэрэг манай улстай өргөн харилцаатай орнууд дээрх конвенцид нэгддэггүй. Тиймээс монголчууд заавал тухайн орны жолооны үнэмлэхийг авах шаардлагатай гэсэн үг. Эсрэгээрээ эдгээр орны иргэд манай улсад ирвэл заавал жолооны дамжаанд сууж, манай улсын үнэмлэхийг авах ёстой.

-Манайх олон улсын жолооны үнэмлэхтэй болно гэж яригдаж байсан. Энэ асуудал юу болсон бэ?

-2015 оны есдүгээр сарын эхээр хэрэгжиж эхэлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад олон улсын жолооны үнэмлэхийн талаар орсон байдаг. Венийн конвенцид нэгдсэн орнуудын болон манай улсын иргэдэд Лицензийн төвөөс уг үнэмлэхийг гурван жилийн хугацаатай олгохоор заасан. Үүний тулд өргөдөл, иргэний үнэмлэх болон жолооны үнэмлэхийн албан ёсны хуулбар, жолооны бүртгэлийн хуудас, цээж зураг, үнэмлэхийн үнэ төлсөн баримт зэргийг бүрдүүлэх шаардлагатай. Гэхдээ уг үнэмлэхийг албан ёсоор олгож эхлээгүй байна. [31M]

АНХААРУУЛГА

Баярын өдрүүдэд орон нутгийн замын хяналтыг эрчимжүүлнэ

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Сар шинийн баярын үеэр цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилладаг. Өнгөрсөн жилийн баярын өдрүүдэд Замын цагдаагийн алба нийт 1089 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас зам тээврийн ослын 351 дуудлага бүртгэгдэж, 50 хүн хүнд, хөнгөн гэмтсэн

бол нэг хүн амь насаараа хохирсон хэрэг гарч байв. Тэгвэл энэ жил цагдаагийн байгууллагын алба хаагчид баярын өдрүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, иргэдийг аюулгүй зорчуулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах аж. Энэ ажилд цагдаагийн бие бүрэлдэхүүнээс гадна ХСИС-ийн сонсогчдыг дайчлах юм байна.

Баярын үеэр иргэдийг овоо тахилга руу гарахдаа тусгайлан зассан зам, талбайд

тээврийн хэрэгслээ байршуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй болон хурд хэтрүүлэхгүй байхыг анхаарууллаа. Мөн шинийн 2-ны өдрөөс хойш орон нутгийн замд хөдөлгөөнт эргүүл, пост ажиллуулж, хурд хэмжих болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг таслан зогсоох, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд тавих хяналтыг эрчимжүүлэн ажиллана гэж Замын цагдаагийн албанаас мэдээллээ. [31M]

зөвлөгөө

Гагнуурын ажил хийх бол аккумулятороо салгаарай



"Доктор" авто сүлжээний инженерүүдийн жолооч нарт зориулсан багц зөвлөгөөг хүргэж байна.

• Өвөл бакан дотор конденсац явагдсанаас хананд нь чийг үүсэж, шатахууны чанарыг муутгах, труп дотор зэврэлт, хөлдөлт үүсгэх аюултай. Үүнээс сэргийлэхийн тулд үргэлж талаас дээш шатахуунтай байлгаарай.

• Цастай замд эгнээ байр солихдоо дохиогоо заавал өгч, аажим шилжилт хийж байгаарай. Огцом хөдөлгөөн бусдыг ч, өөрийгөө ч сандралд оруулдаг.

• Кропны тос ихдэх эсвэл багадвал хөөсрөлт явагддаг. Хөөс гэдэг нь хий учраас насост хий сорогдож, дискэнд тос биш

хий очих учраас араа солигдолт удааширч, дискний насжилт богиносдог. Тиймээс кропны тосыг ихдүүлж эсвэл багадуулж болохгүй, яг таарсан байх ёстой.

• Машинадаа гагнуурын ажил хийлгэх бол заавал аккумуляторыг салгах хэрэгтэй. Ихэвчлэн хасах туйлыг нь салгаж гагнуурын ажил хийлгэдэг. Ингээгүйгээс болж гал хамгаалагч, цаашлаад компьютер болон бусад цахилгаан хэрэгсэл шатах аюултай.

• Муудаагүй ч гэсэн хуучин аккумулятороо хүйтэн гаражид эсвэл гадаа хадгалах гэж байна уу. Тэгвэл зөв хадгалах горимыг мөрдөөрэй. Ямар ч цэнэггүй аккумуляторыг хүйтэнд байлгавал доторх шингэн нь бага хэмд л хөлдчихдөг. Ингэснээр дахин хэрэглэх боломжгүй

болно. Тиймээс заавал бүрэн цэнэглэж байж хадгалаарай. Харин гэртээ хадгалах бол эрүүл мэндэд сөрөг байдгийг бодолцоорой.

• Амортизатор муудаж тосоо гоожуулсан, дуугарч ажиллагаагүй болсон бол өвөл, зун гэлтгүй шууд солиулаарай. Учир нь эргэх, огцом тоормослох үед тухайн машины хүндийн төв шилжиж байдаг. Үүнийг амортизатор аль болох шилжүүлэхгүй, хүндийн төвийг барьж, аюулгүй байдлыг хангадаг.

• Хүйтэнд машинаа дөнгөж асаасны дараа паараа ажиллуулаад нэмэргүй. Хөргөлтийн шингэн халах хүртэл буюу усны заалт дээшлэх хүртэл тохиргоог халуун дээр тавьсан ч хүйтнээр үлээнэ. Ингэж сэргийлснээр паарны сэнсний элэгдлийг багасгаж, дуу орохоос сэргийлнэ.

• Дугуй бүрэн гүйцэд зогсоогүй байхад товчлуурыг даран "P" байрлалд шилжүүлж болохгүй. Хүчилбэл хөдөлгүүрийн эд ангид эвдрэл үүсгэх тохиолдол бий. Түүнчлэн бага хурдтай явж байхдаа P-Parking араанд шилжүүлбэл машиныг хүчээр зогсоож, эвдрэлд хүргэх эрсдэлтэй.

NNC NATIONAL NEWS CORP.

Bloomberg
TV MONGOLIA

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЭТГҮҮЛЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд мэдээ сурвалжилга бэлтгэж нийлүүлэх, хөтөлбөрт мэдээ танилцуулах, мэдээний болон техникийн ажилтнуудтай багаар хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Эдийн засаг, бизнесийн тодорхой салбарыг хариуцан ажиллаж, мэдээ сурвалжилга бэлтгэх
- Салбарын бизнес, зах зээлийн судалгаа хийх, биржд бүртгэлтэй компаниудын тайлан, гол үзүүлэлтүүдэд анализ хийх, төлөв таамаг бэлтгэж танилцуулах
- Шууд болон шууд бус хөтөлбөрт мэдээ, сурвалжилга танилцуулах, зочидтой ярилцах, яриа авах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, бизнес, санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, зах зээлтэй холбоотой аль нэг салбарт ажиллаж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийх туршлагатай
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Мэдээллийг цуглуулах, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай.

ОРЧУУЛАГЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд гадаад мэдээ сурвалжилгыг орчуулан бэлтгэж нийлүүлэх, шууд хөтөлбөрт гадаад мэдээний синхрон орчуулга хийх, гадаад нэвтрүүлгийн орчуулга хийх, бүтээлийн багуудтай хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Олон улсын харилцаа, эдийн засаг, улс төр, бизнесийн салбарын мэдээлэл орчуулах
- Дээрх сэдвээр шууд болон шууд бус хөтөлбөрт орчуулга хийх,
- Олон улсын сүлжээ, агентлагуудаас хүлээн авсан мэдээ сурвалжилга, ярилцлагыг орчуулах, дуу оруулах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Англи хэлний орчуулагчийн бакалавраас доошгүй зэрэгтэй (орос хэлтэй бол давуу тал болно)
- Эдийн засаг, бизнесийн салбар, танин мэдэхүйн нэвтрүүлгийн орчуулга хийх бүрэн чадвар, туршлагатай (аман болон бичгийн орчуулга хийж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Англи, монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажилд туршлагатай
- Эдийн засгийн аль нэг салбар, зах зээлтэй холбоотой ажил хийж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Бусадтай харилцаа, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Интернэтийн орчинд ажиллах, компьютер ашиглах мэдлэгтэй, программ дээр ажиллах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг "BLOOMBERG TV MONGOLIA" телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүдээлгэн өгнө үү.
Хаяг: Блю Скай таур, 4 давхар, № 403, Энхтайвны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол Улс, Холбоо барих утас: 70102020

Лавлах

ОНЦЛОХ ҮЗВЭР


Өвөрмөц дэгээр магтаал хайлна



Монгол Улсын батламжит туульч Алтайн Урианхайн Л.Баатархүү "Алтай хангайн магтаал"-ыг бүрэн хайлах зан үйлийг Богд хааны ордон музейд ням гарагт 11.00 цагт хийнэ. Магтаалыг өвөрмөц дэгийн дагуу хайлах аж. Мөн энэ үеэр ахмад туульчдад хүндэтгэл үзүүлж, тууль уламжлах ёслол гүйцэтгэнэ. Цуур, хэл хуур нь лус савдагийг аргадаж зөөллөдөг бөгөөд туульчид Цагаан сарын битүүнд "Алтай хангайн магтаал"-ыг хайлж, байгаль, лус савдагаа аргадан, ирэх жилийнхээ өнгийг засдаг уламжлалтай байжээ. [31M]

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	II.24	II.25	II.26	II.27	II.28
	-3° / 7 м/с -16° / 6 м/с	-2° / 7 м/с -15° / 5 м/с	-3° / 8 м/с -14° / 4 м/с	-3° / 6 м/с -14° / 4 м/с	-2° / 5 м/с -14° / 4 м/с
Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ



ҮЗВЭР

УЛСЫН ФИЛАРМОНИ
"Бүсгүй минь инээмсэглэж яваарай" олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулсан тоглолтыг ирэх сарын 8-нд 19.00 цагт тоглоно.

"ИМАХ" КИНО ТЕАТР
Монголд Жамесийн бүтээл "Logan" кино ирэх сарын 3-нд нээлтээ хийх гэж байна.

МУЭСТО
"Цагаан сар" үзэсгэлэн худалдаа энэ сарын 26-ныг хүртэл үргэлжилнэ. Үзэсгэлэнд тавгийн боов, цагаан идээ, гарын бэлэг, дээл, гоёл чимэглэл гээд олон төрлийн бүтээгдэхүүн худалдаж байна.

SHANGRI-LA MALL
Америк, Канад, Австрали, Швейцарь, Малайз, Малайз, Сингапур, Солонгос, Испани, Австри, Франц, Итали болон Латин Америкийн орнуудад бакалавр магистр ба хэлний курс тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах төлөөлөгч нартай уулзах боловсролын үзэсгэлэн гуравдугаар сарын 12-нд 09.30 цагт.


THE CORPORATE HOTEL AND CONVENTION CENTRE
Морин хуурын чуулгын "Playing love" концерт гуравдугаар сарын 7, 8-нд болно.

МУГЖ Х.Лхагвасүрэн, СТА дуучин Дэлгэрмөрөн, "Хар сарнай" хамтлагийн дуучин С.Амармандах нарын хамтарсан уран бүтээлийн "Үзэсгэлэнт минь" тоглолт гуравдугаар сарын 8-нд 19.00 цагт.

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09:00 "Тунгалаг тамир" МУСК нэгдүгээр анги	07:30 "Амжилтад хязгаар үгүй" нэвтрүүлэг	09:00 "Cook Club" хоолны шоу нэвтрүүлэг	09:30 Тог тог (season-3) 84 дүгээр хэсэг
12.00	11:55 "Ээждээ захидал бичээрэй" уралдаанд зориулав	11:00 "Made In Mongolia: Улаанбаатар гурил ХХК" нэвтрүүлэг	11:15 "Агуу тэсрэлтийн онол" ОАК 12-13 дугаар анги	11:40 "Гурван баавгай" хүүхэлдэйн кино 55 дугаар анги
14.00	14:00 "Нүүдэл" цуврал нэвтрүүлэг	14:00 "Студио 1.0" нэвтрүүлэг	14:10 "Аяг таа" шоу нэвтрүүлэг	15:00 Өөрчлөлт (season-1) 86 дугаар хэсэг
18.00	17:10 Соно студи: "Маамуу нааш ир"	17:00 "Bloomberg Surveillance"	17:50 "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	18:00 "Наашаа цаашаа" нэвтрүүлэг
20.00	21:40 "Баасан гараг" цэнгээнт нэвтрүүлэг (шууд)	20:00 "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг	20:40 "Mongolia's next top model" шоу нэвтрүүлэг тойм	21:00 "Эмч нар" СОАК 11 дүгээр анги
22.00	22:40 "Тунгалаг тамир" МУСК хоёрдугаар анги	22:00 "Гол сэдэв" нэвтрүүлэг	22:10 "Шадар гурван цэрэг" ОАК наймдугаар анги	22:30 "Скандал" ОАК (season-5) зургадугаар анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 28
Өвлийн адаг цагагчин үхэр сарын нэг цагаан мэнгэтэй хар морь өдөр.
Үс засуулбал: Хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх: 07.40-18.29
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Төмөр

Аргын тооллын хоёрдугаар сарын 24. Сугар гараг. Билгийн тооллын 28. Яруу эгшигт одтой, хар морь өдөр.

Өдрийн наран 07.40 цагт мандан, 18.29 цагт жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрээд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ҮЙЛЧИЛГЭЭ

Баяраар 133 автобус нэмж явуулна



Б.Бямба
ЗГМ

зорчигч тээврийн үйлчилгээг 71 чиглэлд 889 тээврийн хэргэсэл явуулах юм байна.

Дашрамд дурдахад, он гарсаар хот хооронд энэ сарын 20-ны байдлаар 300 мянга гаруй зорчигч тээвэрлэжээ. Харин аймаг, сум хоорондын тээвэрлэлтийн үйлчилгээг 19 аймагас 175 чиглэлд гүйцэтгэдэг аж. Мөн энэ сарын 20-ны байдлаар 55.5 мянган зорчигч тээвэрлэсэн байна. [31M]


ЗГМ: СУДОКУ

		3		2				6	
8	6		1	4		3	9		
	5	4	9	6				2	1
	4	8				1			
	2	5	3				4		
						5	3		
		6		3	9	2	8	7	
	8			1	4				
4	3				5	9			

4	6	5	3	2	7	8	1	9	
9	2	1	8	5	4	7	3	6	
3	8	7	9	1	6	2	4	5	
7	1	9	2	8	5	4	6	3	
8	3	4	1	6	9	5	7	2	
6	5	2	4	7	3	1	9	8	
5	4	8	6	9	1	3	2	7	
2	9	3	7	4	8	6	5	1	
1	7	6	5	3	2	9	8	4	

(Өмнөх дугаарын хариу)

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Ямаат тогтоох хэллэг
2. Мужааны багаж

3. Араатны хаан
5. Мөчир
7. Хүн төвлөрсөн газар
9. Мужааны багаж

10. Дутуу биш, давамгай
13. Төр, засгийн бодлого хэрэгжүүлэх

байгууллага

14. Онолох цэг
15. Шоглож даваадуулсан үг

ХӨНДЛӨНГӨӨР:

3. ...мана
4. Бэлчээрийн ургамал
6. Хүүхдүүд

7. Салаа үзүүртэй эд

10. Бага биш, арвин
11. Чингис хааны Хулан хатнаас гарсан хүү
12. Тооны нэр
14. Гурилан бүтээгдэхүүн
16. Муурын зулзага

Өмнөх дугаарын хариу / 02.23

Т	О	Т	Ь	О	Ц	О	Н
		У		Ц		Э	
Г	Ү	Н	Г	Э	Р	В	А
Р	Г		Н		Э		Н
А	Т	А	А		Г	Э	Р
Н	А		З		Н		И
Т	Э	М	Э	Э	Н	Ж	И
		А		Л		А	
З	А	Л	Ь		И	В	А

Талын чоно шиг хийморьлог Тавиун сэтгэлт түмэн минь Тавтай сайхан шинэлээрэй.

ДААТГАЛ
SINCE 1994

Ердийн даатгал

КРЕДИТ
ББӨБ

Банк бус санхүүгийн байгууллага

АКТИВ
ХЗХ

Хөдөлмөж зээлийн хоршоо

СЕКЮРИТИЗ
ҮҮЦ

Брокер, диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх

МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

Хөрөнгө оруулалтын менежмент

ШУУДАН

Шуудангийн Цэцэг Шийдэл

EIT EQUITY INVESTMENT TRUST

Хөрөнгө оруулалтын сан

БОМЫН ХИШГЭ
ХӨВӨЛӨЙН ГАЗАР

Үл хөдлөх хөрөнгийн түрээс

TENGER SYSTEMS

Санхүүгийн програм хангамж

МОНГОЛЫН ЦЭГ ЦЭВРИЙН МЯГДСАН ДАНС

Хөрөнгө оруулалтын сан

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН

Хөрөнгө оруулалтын сан

Алтан Хоромсог
Брокер, Диллерийн Компани

Хүчтэй. Хамтдаа.

(976) 7707 8080
info@ardholdings.com
www.ardholdings.com
цэнэг.зрддэмтэй.өнгөлөх

Өмнөд Солонгос наслалтаар дэлхийд тэргүүлнэ

2030 онд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 90-ийн босгыг давахын сацуу Азийнхан Европынхоос олон болно гэв. > 10

Амьдрал байх боломжтой гарагуудыг нээжээ

Сансар судлаачид хамгийн том бүлэг гарагийг илрүүлсэн нь урьд үзэгдээгүй том нээлт боллоо гэж эрдэмтэд үзэж байна. > 10

Парисын шинэ бизнес төв

Францын нийслэл Парис хот санхүүгийн үйлчилгээний компаниудыг Лондоноос татан ирүүлэхийг эрмэлзэж байна. > 10



Францын саармагжсан баруун, хуваагдмал зүүн, хариуцлагагүй төвч хүчний урагшгүй байдал Үндэсний фронт намд хожоо болж байна.

намаас нэр дэвшигч Франсуа Фийон сонгуульд хялбархан ялах нь гэсэн бодол анх хүчтэй байв. Гэтэл 20 гаруй жил парламентын мөнгөөр гэрийнхнийгээ тэжээж байсныг нь Le Canard Enchaonий шог сонин илрүүлж орхисноос хойш ноён Фийон хэл амны бай болж хувирав. Тэрбээр нийтэд хандан уучлалт гуйсан ч нэгэнт дэгдсэн хэрүүл сонгуулийн өрсөлдөөнд нь гай тарилаа. Тэгээд ч Саркозигийн үед таван жил Ерөнхий сайдаар ажилласан хүний суурь өөрчлөлт хийх амлалтад сонгогчид төдийлэн

Санал асуулгын дүнгээс үзвэл түүнийг дэмжигчдийн тоо өссөөр байгаа.

Гэхдээ ноён Макронд хүртэл “эмзэг газар” бий. Алжир дахь Францын колоничлолын үеийг тэрбээр “Хүн төрөлхтний эсрэг өдүүлсэн гэмт хэрэг” хэмээн тодорхойлдог нь тус улсын консерватив үзэлтнүүдийн дургүйг хүргэдэг. Элитүүд нь Францын колонийн өв уламжлалыг сахин хадгалах чадваргүй болсны илрэл нь ноён Макрон өөрөө. Францын элитүүдийг бэлтгэдэг Icole Natio-

хүний дэвшүүлдэг бодлого шинэ үндсэн хууль боловсруулах замаар “Зургадугаар бүгд найрамдах улс”-ыг тунхаглах, одоогийн зөрчилтэй хөдөлмөрийн хууль тогтоомжуудыг цуцалж, баян чинээлэг хэсэгт ахиу татвар оноох зэрэг ижил төстэй зүйлс их бий. Энэхүү нийтлэг тал нь Олландын засаглалын үед гаарч гүйцсэн зүүний хүчний төлөөллийг улам бэхжүүлэх үндэс болно. Юутай ч “Өөрийгөө булшилж орхих тэнэг юм хийхгүй” хэмээн ноён Меланшон мэдэгдсэн болохоор зүүний хүчний төлөөлж буй хоёр эрхэм одоохондоо тохиролцохгүй шинжтэй.

Францын саармагжсан баруун, хуваагдмал зүүн, хариуцлагагүй төвч хүчний бүтэлгүй байдал нь Марин Ле Пен болоод пужадист уламжлалаа сахигч Үндэсний фронт намд хожоо болж байна. Гол өрсөлдөгчдийнхөө аль нэгэнд ялагдах магадлал нь багассаар байгаа хатагтай Ле Пен Ерөнхийлөгчийн сонгуульд тэргүүлэх нь ойлгомжтой. Франц орон Үндэсний фронт намын Ерөнхийлөгчтэй болно гэсэн таамаг саяхан болтол санаанд багтамгүй зүйл байв. Тэгвэл таамаг бараг л үнэн болох нь. Францын улс төрийн элитүүд хамтын чармайлт гаргахгүй бол пужадист “Frexit”, Трампыг бишрэн шүтэгч хатагтай тавдугаар сард Елисейн ордонд эзэн сууна.



Марин Ле Пенгийн ялах боломж таамаглалаас хавьгүй их

Судир Хазаресингх

Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн гол онцлог нь тус улсын уламжлалт тогтолцоо эрс хувирч болзошгүй явдал. Николя Саркози, Ален Жюппе зэрэг урьдны консерватив удирдагчид Бүгд найрамдах намын сонгуулийн эхний шатанд ялагдах хүлээлээ. Нэр хүндээ унагасан Франсуа Олланд өрсөлдөөнөөс татгалзсан нь Францад Ерөнхийлөгч анх удаа

дахин сонгогдох чадваргүй болсон хэрэг байв. Илүү радикал Бенуа Амон Ерөнхий сайд Мануэль Вальсийг Социалист намын сонгуулийн эхний шатны өрсөлдөөнд унагаж орхисон нь байдлыг бүр ч нэрмэв.

Тогтолцооны эсрэг энэ бүх үйл явц нь Brexit болон Дональд Трампын ялалтын шалтгаан болсон Англо-Америк бужигнааны цууриа болов. Нөгөө талаар Францын иргэд улс төрийн

намуудад итгэхээ больсон нь оршин буй тогтолцооны эсрэг популист уламжлалтай нь ч холбоотой. Францын 1950-иад оны популист улстөрч Пьер Пужадын “Sortez les sortants” буюу “Таргаад хая” гэсэн алдарт хэллэг 2017 оны сонгуулийн кампанийн уриа болж чадна.

Энэ удаагийн сонгуулийн кампани улс төрийн донсолгоо, санаанд оромгүй эрс өөрчлөлт дунд өрнөж байна. Бүгд найрамдах

үнэмшихгүй байсан юм.

Ноён Фийонд тохиолдсон гай түйтгэр Эммануэль Макронд ивээлтэй. Олландын Засгийн газарт Эдийн засгийн сайд байсан, төвч үзэлтэй тэрбээр сонгуульд бие даан өрсөлдөгч. Нас залуу, эрч хүч, оюуны чадавхтай, космополит төрх бүхий ноён Макрон францчууд зүүн, барууны чийртэй хэрүүлээс залхаж гүйцлээ хэмээн тайлбарладаг нь сонгогчдын сэтгэлд нийцдэг.

nale d'Administration-ийг төгсөгч, Rothschild-д ажиллаж байсан туршлагатай банк санхүүгийн мэргэжилтний байр суурийг хүн амын хуучинсаг хэсэг дэмжих нь эргэлзээтэй.

Ноён Фийон, Макрон хоёр сонгуульд хангалттай санал авч дөнгөхгүй бол зүүний хүчний гол хоёр өрсөлдөгч, адилхан прогрессив популист болох ноён Амон, Жан-Люк Меланшон нарт боломж гарч ирнэ. Энэ хоёр

Хятадын хориг нь бодлого өөрчлөгдөж буйн дохио

Чарльз Кловвер, Брайан Харрис

Умард Солонгосын цөмийн хөтөлбөрт хориг тавих ажиллагааг тасалдуулагчийн үүрэг гүйцэтгэгч БНХАУ нь НҮБ-ын шийдвэр хэрэгжих явцыг сулруулж байна гэсэн шүүмжлэлд олон жилийн турш өртсөөр ирлээ. Гэтэл Бээжин Умард Солонгосоос импортлох нүүрсэнд энэ оны эцэс хүртэл хориг тавьснаа өнгөрсөн бямба гарагт зарласан нь шинжээчдийг гайхшруулсан үйлдэл болов. Бээжингийн шийдвэр нь хөрштэйгөө харьцах стратегия тодорхойлох үүднээс Пхеньяныг өдсөн түр арга хэмжээ юу, эсвэл өөр учир байна уу гэсэн асуулт тавихад хүргэлээ.

Хятадын эрх баригчид Умард Солонгосын эдийн засгийг сүйрүүлэх зорилго агуулжээ гэсэн таамагт ихэнх шинжээчид эргэлзэж байна. АНУ-ын хувьд Пхеньянд дэглэм өөрчлөгдөх нь чухал. Гэтэл Умард Солонгосыг цөмийн зэвсэггүй болгохын төлөө улс орныг нь тогтворгүй байдалд оруулж, дэглэмийг нь нурааж болохгүй хэмээн БНХАУ үздэг. Дэглэм нурвал Хятадыг зорьсон дүрвэгсдийн урсгал үүсэх, эсвэл АНУ-ын тал баримталсан Засгийн газрын удирдлага дор Солонгосын хойг нэгдэх аюултай хэмээн Бээжин болгоомжилж байгаа.

Юутай ч нүүрсний импортод хориг тавьсан нь Пхеньянд хүндрэл учруулж, валютын хомсдлыг нь гүнзгийрүүлнэ. Бээжингийн хориг нь дорнод Азийн зожиг улсад нэг тэрбум ам.доллар буюу дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувьтай нь тэнцэх хохиролтойг Goldman Sachs-ийн эдийн засагч Квон Гу Хун тооцоолжээ. Харин бохир утааг бууруулах арга хэмжээний хүрээнд нүүрс олборлолт, импортоо багасгаж буй БНХАУ-ын хувьд уг хориг онцын нөлөөгүйг шинжээчид өгүүлж байна.

“Улс төрийн эрс шийдвэр нь дээд удирдлагын тэвчээр барагдсаны илрэл” хэмээн Жон Хопкинсын их сургуулийн

АНУ-Солонгосын хүрээлэнгийн Умард Солонгосын судлаач Уильям Ньюкомб хоригтой холбогдуулан бичсэн блогтоо тайлбарлав. Уг хориг нь өнгөрсөн долоо хоногт Куала Лумпурын нисэх буудалд Умард Солонгосын удирдагч Ким Жон Уны эх ондоотой ах Ким Жон Намыг хөнөөсөнтэй холбогдуулан Бээжингээс Пхеньяныг нийтийн өмнө цээрлүүлж буй арга байж болзошгүй. Бээжинтэй нягт хэлхээ холбоотой Ким Жон Нам нь БНХАУ-ын хамгаалалт дор Макао амьдарч байсан юм. Умард Солонгос баллистик пуужин туршсаны маргааш нь тэрбээр бусад хорлуулжээ.

Харин Вашингтон дахь Стратеги, олон улсын судалгааны төвийн Хятадын мэргэжилтэн Бонни Глэйзер өөр таамаг дэвшүүлэв. БНХАУ нь Пхеньянд хэт зөөлөн ханддаг хэмээн шүүмжлэгч Цагаан ордныг тайвшруулж буй хэрэг хэмээн тэрбээр үзэж байна. “Минийхээр бол Хятадын хориг хоёр зорилготой. Эхнийх нь Ким Жон Намыг хөнөөсөнд дургүйцэж буйгаа Пхеньянд ойлгуулах. Нөгөө нь намын XIX их хуралтай холбогдуулан АНУ-Хятадын харилцааг тогтворжуулах үүднээс Трампын засаг захиргаанд тал засах” хэмээн ноён Глэйзер өгүүлсэн юм.

Энэ намар Бээжинд болох их хурлаар тус улсын дарга Ши Жиньпийн залгамжлагч тодрох магадлал их. Үүний зэрэгцээ хатуу арга хэмжээ авах АНУ-ын шаардлагад нийцүүлэн, Умард Солонгосын асуудлаар Вашингтонтой тохиролцооор эрмэлзэж буйгаа харуулж байгаа хэрэг ч байж болно хэмээн мэргэжилтэн тайлбарлав. “Умард Солонгосыг шийтгэхэд зүтгэл гаргахгүй байна гэсэн өрнөдийн байнгын шүүмжлэлд Хятад улс хариулж байгаа нь энэ болов уу” хэмээн Фудань их сургуулийн Солонгос судлалын төвийн профессор Цай Жянь таамаглав.

БНХАУ-ын Худалдааны яамнаас тавьсан хориг хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдөр Мюнхенд чуулсан Аюулгүй байдлын хуралдаан дээр Бээжингийн төлөөлөгчөөс оролцогч талуудыг хэлэлцээний ширээний ард цуглахыг уриалсан. “Хуучин яриа хэлэлцээг хангалтгүй гэж үзэж буй Хятад улс та бүхэнтэй хамт гэдгээ батлах байна” хэмээн БНХАУ-ын Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын Гадаад хэргийн хорооны тэргүүн Фү Ин өгүүлэв.

Пхеньяны цөмийн хөтөлбөрийн асуудлаар Умард Солонгосын хөрш улсууд, АНУ оролцсон зургаан талын яриа хэлэлцээ хамгийн сүүлд 2009 онд болжээ. Сүүлийн таван жилд уг асуудлаар албан бус яриа хэлэлцээ ч болсонгүй өнгөрлөө. Хатагтай Фу-гийн мэдэгдэл нь нүүрсний хориг сайн санааны илэрхийлэл болохыг илтгэж байна. Харин Бээжин сайн санааныхаа хариуд яриа хэлэлцээ өрнүүлэх хүсэлтэй. “Хятад улс Умард Солонгост шахалт үзүүлж байгаа нь Трампын засаг захиргаатай хамтран ажиллах эрмэлзэлтэйгээ харуулах ганц л зорилготой” хэмээн Олон улсын судалгааны Питерсон хүрээлэнгийн шинжээч Стефан Хаггард блогтоо бичжээ.

Бохир утааг багасгах арга хэмжээний хүрээнд нүүрс олборлолт, импортоо багасгаж буй БНХАУ- дуг хориг хохирол учруулж чадахгүйг шинжээчид онцлон анхааруулдаг. Үүний зэрэгцээ Умард Солонгосоос нүүрс импортлоход хязгаар тогтоосон НҮБ-ын шийдвэрт заасан хэмжээнд Хятад улс хүрчихсэн ч байж болзошгүй. “Хятадын нүүрсний импортын нэг, хоёрдугаар сарын статистик нийтлэгдэх цагт тус улс Умард Солонгосоос худалдан авсан нүүрс НҮБ-ын 2321 тоот шийдвэрт заасан хэмжээнд тулсан дүнтэй байвал би лав гайхахгүй” хэмээн ноён Глэйзер өгүүлсэн юм.



УЛААНБААТАР ХОТЫН БАНК



ЭРХЭМ ХАРИЛЦАГЧ ТА САР ШИНЭДЭЭ САЙХАН ШИНЭЛЭЭРЭЙ

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Өмнөд Солонгос наслалтаар дэлхийд тэргүүлнэ

Брайн Харрис

2030 онд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 90-ийн босгыг давахын сацуу Азийн тэтгэврийнхэн Европынхоос олон болно гэсэн судалгаа нийтлэгджээ. Эндээс үзэхэд өмнөд солонгосчууд хамгийн урт настай үндэстэн болж, олон жил тэргүүлсэн япончуудыг ардаар орхих нь. Өмнөд Солонгосын эмэгтэйчүүдийн дундаж наслалт 2030 онд ерээс дээш гарснаар эрүүл мэндийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хандлага давамгайлах байх гэж судлаачид дүгнэжээ.

Лондоны эзэн хааны коллежийн эрдэмтэд Британи, АНУ хөгжилтэй орнуудын дундаж наслалтаар хамгийн доогуур бичигдэх төлөвтэй байгаа талаар маргаан өрнөөд буй үед судалгааны тайлангаа нийтлүүлсэн байна. 2030 онд энэ хоёр улсад эмэгтэйчүүдийн дундаж нас 83, эрэгтэйчүүдийнх 80 байна гэж таамаглажээ. Судалгааны багийн ахлагч Мажид Эззати “Өрнөдөд хэмээлт, тэгш бус байдал өсөж буйтай харьцуулахад дорнын

улсуудад эсрэг хандлагатай байна” хэмээн өгүүлэв. Өмнөд Солонгосын эмэгтэйчүүд 2030 онд дундаж 91 насална гэсэн тооцоо гарсан бол эрэгтэйчүүд нь ч бас харьцангуй өндөр 84 хүрэх аж.

Энэхүү үзүүлэлт нь Өмнөд Солонгос сүүлийн 60 жилд дайны хөлд сүйдэж ядуурсан орноос орчин үеийн, технологийн өндөр хөгжилтэй улс болон хувирсныг харуулж байгаа юм. Ерөнхий эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна анагаах ухааны Lancet сэтгүүлд бичсэнээр боловсрол, хүүхдийн хоол тэжээл болон эрүүл мэндийн шинэ технологид үсрэнгүй дэвшил гарах төлөвтэй байна. Мөн судалгаанд өмнөд солонгосчууд биеийн жин ба цусны даралт багатай болохыг дурджээ.

Уг дүгнэлт тус улсын залуу үеийнхэнд илүү ачаалал ирэхийг харууллаа. Бусад судалгаанаас үзэхэд Азийн Хятад, Тайланд зэрэг улсад 2050 он гэхэд 65-аас дээш насныхны нийт хүн амд эзлэх хувь хэмжээ өрнөдийн орнуудаас давна гэсэн таамаг дэвшүүлжээ. Өнгөрсөн оны нэг



2030 онд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 90 насны босгыг давахын сацуу Азийн тэтгэврийнхний тоо Европынхоос олон болно.

баримтыг харвал 65-аас дээш насны солонгосчуудын бараг тал нь ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байгаа юм. Өнөөдөр их сургуулийн анагаахын профессор Пак Ен Чеол наслалт нэмэгдэхийн сацуу төрөлт буурч байгааг анхааруулсан. Тэрбээр “Өмнөд Солонгост төрөлтийн түвшин

доогуур байгаа нь нэг талаар нярайн эндэгдэл маш бага байгаатай холбоотой. Энэ байдал дундаж наслалтыг тооцоход нөлөөлдөг” гэсэн юм.


Урт наслалтын бэлгэдэл болдог Япон улс дундаж наслалтын үзүүлэлтээр доошлох шинжтэй боллоо. Эмэгтэйчүүдийн наслалтаар

Японыг Өмнөд Солонгос, Франц хоёр ардаар орхих төлөвтэй байна. Эрэгтэйчүүдийн хувьд одоогийн дөрөвдүгээр байрнаас 11 рүү ухрах таамаг гарчээ. 2030 он гэхэд АНУ-ын хүн амын дундаж наслалт Мексиктэй зэрэгцэж магадгүй. Энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний доройтол, эхийн болон хүүхдийн эндэгдэл, хүн

амины хэрэг зэргээс шалтгаалах аж. Профессор Эззати хүний ерөнхий наслалт аажмаар нэмэгдсээр 110-120 хүрэх боломжтой хэмээн дүгнэв. Тэрбээр “Энэ бол дээд хязгаар байх гэж төсөөлж байна. Гэхдээ бид үүнд хүрэхэд хол байгаа” хэмээн ярилаа.



Амьдрал байх боломжтой гарагуудыг нээжээ



Trappist-1 гарагийн атмосфер дэх хүчилтөрөгч, метан, нүүрсний давхар исэл болон усны илрэл нь биологийн идэвхжиллийн нотолгоо байж болох юм.

Клайв Куксон

Сансар судлаачид амьдрал байх боломжтой хамгийн том бүлэг гарагийг илрүүлсэн нь урьд үзэгдээгүй том нээлт боллоо гэж эрдэмтэд үзэж байна. Тэдгээр нь дэлхийгээс дөчин гэрлийн жилийн цаана оршдог аж. Бельгийн Льежийн их сургуулийн ивээл доор ажилладаг олон улсын сансар судлаачдын баг гарагийн систем нээсний дотор дэлхийн хэмжээтэй долоон гарагийн гуравт нь амьдрал үүсэх боломжтой гэдгийг тогтоов. Уулан дээр болон сансарт байрлуулсан арван дуран авайгаар ажигласны дүнд хийсэн нээлтийн тайланг Nature сэтгүүлд нийтлүүлжээ. Гарагуудын систем нь харьцангуй хүйтэн, жижиг Trappist-1 хэмээх улаан одыг тойрон эргэнэ. Энэ од нарны жингийн найман хувьтай тэнцэх агаад түүний гэрлийн 0.5 хувийг гаргах эрчим хүчтэй.

Өнөөг хүртэл нарны системээс гадна галактик exoplanet хэмээх одон гарагуудыг эрж хайх явдал нартай төсөөтэй одод дээр төвлөрч, 3500 орчмыг

нээгээд байсан. Trappist-1-ийг нээсэн нь жижиг улаан оддыг ажиглах судалгааны шинэ чиглэлийг эхлүүллээ. Ийм шинж чанартай од том гарагуудаас харьцангуй олон тоотой байдаг аж. Кембрижийн их сургуулийн профессор Амаури Триауд “Trappist-1-тэй төстэй жижиг орноос цацрах эрчим хүч нь нарныхаас хавьгүй сул. Гадаргын ус бий болохын тулд ийм гарагуудын орбит нь нарныхаас ойрхон байх ёстой” хэмээн өгүүлэв.

Азаар оддын ийм нягт байрлал Trappist-1-ийг тойрсон гарагуудын шинж чанарт нийцэж байна. Галактикийн орон зайн хэмжээсээр авч үзвэл Trappist-1 системийн дэлхийд харьцангуй ойр ба эцэг од нь сулхан гэрэлтдэг жижиг гараг аж. Мөн нартай төстэй бусад exoplanet-ын адил нүд сохлом хурц туяа цацруулдаггүй тул сансар судлаачид ажиглахад дөхөмтэй гэдгээр дэлхийтэй ойролцоо хэмжээтэй агаад чулуулгаас бүрддэг. Тэрчлэн гадаргуу дээрээ далай тэнгистэй байж болох авч дотоод гурван од нь устай байхад хэт халуун, гаднах нэг нь хэт хүйтэн гэж эрдэмтэд үзсэн байна.

Trappist-1-ийн нягт систем нарны аймаг дахь хоёр сартай Бархасбадь гарагтай хэмжээний хувьд ойролцоо. Түүнчлэн нарны аймгийн төвд хамгийн ойр Буд гарагийн тойрог замд багтахуйц орбиттой байж болох юм. Trappist-1-ийн гарагууд болон дэлхийн гол ялгаа нь тэд цөм од

физик шинж чанарт анализ хийх юм байна.

Trappist-1 гарагийн атмосфер дэх хүчилтөрөгч, метан, нүүрсний давхар исэл болон усны илрэл нь биологийн идэвхжиллийн нотолгоо байж болох юм. Ноён Триауд “Бид 10 жилийн хугацаанд тэнд амьдрал байгаа, эсэхийг тогтооно гэж найдаж байна” гэжээ. Түүний баг гарагийн харагдах талаас ирсэн гэрлийн туяаг ашиглан Trappist-1-ийн хэмжээ, орбит, бүтцийн тухай мэдээлэл цуглуулсан юм. Долоон гараг бүгдээр дэлхийтэй ойролцоо хэмжээтэй агаад чулуулгаас бүрддэг. Тэрчлэн гадаргуу дээрээ далай тэнгистэй байж болох авч дотоод гурван од нь устай байхад хэт халуун, гаднах нэг нь хэт хүйтэн гэж эрдэмтэд үзсэн байна.

Trappist-1-ийн нягт систем нарны аймаг дахь хоёр сартай Бархасбадь гарагтай хэмжээний хувьд ойролцоо. Түүнчлэн нарны аймгийн төвд хамгийн ойр Буд гарагийн тойрог замд багтахуйц орбиттой байж болох юм. Trappist-1-ийн гарагууд болон дэлхийн гол ялгаа нь тэд цөм од

руугаа үргэлж нэг талаараа харж байдаг. Иймд гарагийн нэг тал нь үргэлж гэрэлтэй, нөгөө тал нь үргэлж харанхуй байдаг аж. Гэхдээ энэ шинж чанар амьдрал үүсэхэд саад болох хүчин зүйл биш гэж төслийн удирдагч Льежийн их сургуулийн профессор Микаэл Гиллон онцлов. Тэрбээр “Дэлхийнхтэй адил атмосфертэй байгаа учир дулаан өдрийн хэсгээс шөнийн тал руу ууссаж, температурын ялгааг тэнцүүлдэг байх ёстой” гэсэн юм.

Ид шидээр хүнийг Trappist-1-ийн гадаргуу дээр аваачвал “гоёмсог дүр зургийг олж харах байх” гэж ноён Триауд мөрөөднө. Тэрбээр “Дэлхийн өдрийн гэрлээс 200 дахин сул туяа улбар ягаан өнгөөр цацарна. Нар жаргахын өмнөх туяатай адил” хэмээн өгүүлэв. Сансар судлаачид галактикт нээгдсэн exoplanet-ын тоо тасралтгүй өссөөр буйг нотолдог. Хэрвээ жижиг эрхэс том оддын адилаар дотроо олон гарагийг багтаадаг бол Сүүний зам галактикт хэдэн зуун тэрбумаараа байх ёстой. Эрэл хайгуул 

Парисын шинэ бизнес төв



Майкл Стотхард

Францын нийслэл Парис хот бизнесийн дүүрэгтээ долоон өндөр барилга босгож, санхүүгийн үйлчилгээний компаниудыг Лондоноос татан ирүүлэхийг эрмэлзэж байна. Их Британи Европын холбооноос гарч буй үед тэндээс олон улсын корпорациудын толгой оффисийг татах өрсөлдөөнд Европын хотуудын дунд өрнөсөн. Парисын захиргаа 2021 он гэхэд 50 хөлбөмбөгийн талбайтай тэнцэхүйц буюу 375 мянган ам дөрвөлжин метр оффисын талбай бий болгож, хот руу ирэх “шинэ авьяастнуудыг байрлуулна” хэмээн мэдэгдэв. Парисын баруун дүүрэгт бизнес төв байгуулах төслийн захирал Мари-Сели Гиллиам “Лондонын ирээдүйн талаар тодорхойгүй бодолтой байгаа бизнесийнхэнд хүчтэй мессеж илгээнэ” гэлээ.

Британи Европын холбоог орхих шийдвэр гаргаснаас хойш сэтгэл түгшиж эхэлсэн банк, даатгал, старт-ап компаниудыг татах өрсөлдөөнд Франкфурт, Брюссель, Дублин хотууд дээгүүр явж байгаа. Парис энэ хүчин чармайлтад хамгийн идэвхтэй оролцож байна. Өнгөрсөн оны зургадугаар сард Брекситийн санал асуулгын дунд тодорхой болсны дараагаас Ерөнхийлөгч Франсуа Олландын социалист Засгийн газар Парис хотод оршин суугч гадаадынхны татварын журмыг зөвлөсөн. Үүний зэрэгцээ олон улсын компаниудыг татах зорилгоор өндөр түвшний лобби бүлэг байгуулсан билээ.

Тавдугаар сард болох Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх асуулгад тэргүүлж буй бие даасан нэр дэвшигч Эммануэл Макрон Брекситийн дараа Британийн банкууд, эрдэмтэд, авьяастнуудыг Францад ирэхийг урьсан байна.

Гэвч Франц болон Британийн банкуудын дээд тушаалынхан Парис хот Европын санхүүгийн шинэ төв болж чадна гэдэгт итгэл муутай байгаа аж. Тэдний бодлоор Францын хатуу чанга хөдөлмөрийн хууль, хэлний бэрхшээл, өндөр татвар зэрэг нь үүнд саад болж байгаа гэнэ.

Лондонд байрладаг Европын холбоонд хамаатай санхүүгийн зарим үйл ажиллагааг эх газарт шилжүүлэх боломжтой гэж банк, санхүүгийнхэн үзэж байна. Нэгдүгээр сард HSBC банк Брекситийн дараа Лондоноос нүүсэн анхны томоохон санхүүгийн байгууллага болсон. Эднийх 1000 орчим ажилчин байраа Британийн нийслэлээс Парис руу шилжүүлжээ. Түүнчлэн UBS банк Лондон дахь мөн адил тооны ажилтнуудаа нүүлгэх тухай мэдэгдсэн байна. JPMorgan Chase банкны ерөнхий захирал Жейм Даймон Британид байрладаг 16000 ажилтныхаа 4000 орчмыг эндээс шилжүүлж магадгүйг мэдээлжээ. Гэхдээ тэд яг хаана очиж байрлахаа мэдэгдээгүй байна.

Францын санхүүгийн зохицуулагчид өнгөрсөн есдүгээр сард Парист шинээр бүртгүүлэх санхүүгийн компанийн журмыг хялбаршуулсны сацуу бичиг баримтыг англи хэл дээр хүлээн авахыг зөвшөөрсөн юм. Тэд энэ арга хэмжээгээ Брекситийн үүссэн нөхцөл байдалтай холбон тайлбарлажээ. Парист бизнесийнхнийг татах төслийн сурталчилгаа өнгөрсөн оноос эхэлж, Брекситийн дараа бий болсон тодорхой бус байдлыг ашиглан “Манангаас залхсан бол мэлхийн мах амтал” гэсэн уриа гаргажээ. Францад мэлхийн махыг тансаг зоогт тооцдог бөгөөд францчуудыг мэлхий хэмээн шоглон нэрлэх нь бий.



Эдийн засаг

ТАТВАР


Цаасан баримтыг халах ШИНЭЧЛЭЛ

Иргэд худалдан авалт бүрийн мэдээллээ шивж оруулдаг одоогийн системийг хална

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжээд хоёр дахь жилээ угтаж байна. Хууль хэрэгжсэн хугацаанд НӨАТ суутган төлөгч аж ахуйн нэгжийн тоо 2600-гаар нэмэгдэж, 63 мянгад хүрээд буй. Энэ нь хуулийн хэрэгжилт хэр үр дүнтэй байсныг илтгэнэ. НӨАТ-ын тухай хууль иргэдэд татвар төлсөн төлбөрийн баримтаараа сугалаанд оролцох тогтолцоог шинээр бий болгосон. Өөрөөр хэлбэл, иргэдийн худалдан авалтыг урамшуулж, далд эдийн засгийг ил болгоход энэ нь гол үүрэг гүйцэтгэж байна.

Татварын ерөнхий газраас цаасан баримтыг халж, цахим карт нэвтрүүлэхээр төлөвлөж байгааг дуулгая. Энэ нь зардал болон цаг хугацааг хэмнэх ашиг тустайг Татварын ерөнхий газрын дарга Л.Зориг тодотгов. НӨАТ-ын урамшууллын сугалааг энэ онд үргэлжлүүлэхээр болсон. Үүнтэй холбоотойгоор цаасан баримтыг цахим карт руу шилжүүлэх аж. Өнгөрсөн онд 190 гаруй сая баримт хэвлэж, 19 удаа сугалааны



Б.Ганбаяр / ЗГМФ

Шинээр нэвтрүүлэх картны давуу тал нь урамшуулал бодогдох юм.

тохирлыг зохион байгуулсан. Тэгвэл энэ онд 12 удаа сугалааны тохирлыг явуулах бөгөөд 184.2 мянган төлбөрийн баримт азан болох тооцооллыг гаргажээ. Хэрэглэгчийн тоо 900 мянга орчим байна гэж тооцсон байна. Энэ нь хэрэглэгч сард хэчнээн төлбөрийн баримт бүртгүүлэхээ шалтгаалах юм.

Татварын ерөнхий газар өнгөрсөн онд төсөвт нийт 1.5 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлсэн. Үүний 35 хувийг НӨАТ-ийн орлого эзэлсэн. Энэ нь 2015 онтой харьцуулахад 70 тэрбум төгрөгөөр өссөн

дүн. Улсын хэмжээнд цахим баримтын системийг 63.1 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа нэвтрүүлж, 190 гаруй сая баримт хэвлэж өгсөн байдаг. Өдөрт 581 мянган баримт хэвлэхийн тулд есөн мод огтлох шаардлага гарч байна. Харин карт нэвтрүүлж, банкны пос машинд уншуулснаар өдөрт долоон ширхэг мод хэмнэх боломжтой аж.

NFC картын технологийг монгол инженерүүд нэвтрүүлэхээр ажиллаж буй бөгөөд иргэд худалдан авалт бүрийн мэдээллээ шивж оруулдаг одоогийн системийг халах

юм. Өөрөөр хэлбэл, картаа уншуулснаар бүртгэлд хамрагдах хялбаршуулсан хувилбарыг удахгүй ашиглах аж. Шинээр нэвтрүүлэх картны давуу тал нь урамшуулал бодогдох юм. Баримтын автоматжуулалтыг сайжруулж, картны технологид энэ улиралд багтаан шилжүүлэхээр Татварын ерөнхий газар бэлтгэл ажлаа хангаж байна. Өнгөрсөн онд нийт баримтын 45 хувь нь бүртгэгдсэн бол энэ онд 58.9 хувь нь бүртгэгдэх магадлалтай байгааг НӨАТ-ын төслийн нэгжийн дарга Р.Отгонтулга ярилаа.

НӨАТ-ын систем хэрэгжиж

эхэлснээс хойш Х тайлангийн эзлэх хувь 26 хувиар буурсан байна. Технологийн өргөтгөлийн үр дүнд иргэдэд очих цаасан баримтыг цахимжуулахаас гадна санхүүгийн нэгдсэн “тавцан” бий болох аж. Эдийн засагт урсаж буй мөнгө бүрийг бүртгэн далд эдийн засгийг илрүүлэхэд чиглэж буй НӨАТ улс татвараа бүрэн авахад чиглэж буй. Улсад төлсөн татварынхаа 20 хувийг жилийн эцэст буцаан авахаас гадна сар бүр сугалаанд оролцож азан болох нөхцөл бүрдсэн. Энэхүү боломжийг иргэд 100 хувь ашиглах л үлдэж байна. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Газрын тосны хөрөнгө оруулалт өссөн

Г.Илч
ЗГМ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар өчигдөр салбарын ахмадуудаа хүлээн авч уулзлаа. 80 орчим жилийн түүхтэй Монголын газрын тосны салбарын төр, хувийн хэвшилд ажиллаж байсан 80 гаруй ахмад уулзалтад оролцсон байна. Стратегийн ач холбогдол бүхий энэ салбар Монгол Улсад үүсээд 76 жилийн ой тохиож буй аж. Ойн хүрээнд хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн. Тухайлбал, салбарын ахмадууд нэгдэн, хороо байгуулж буй аж. Ингэснээр тэд дуу хоолойгоо хүргэж, ахмад, залуу үеийн хэлхээ холбоо бэхжинэ гэж үзэж байна. Энэ үеэр Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны асуудал хариуцсан орлогч дарга Л.Раднаасүрэнгээс зарим зүйлийг тодруулав.

-Энэ онд хэд орчим тонн газрын тос олборлож, экспортлохоор төлөвлөж байна вэ?

-2017 онд 1.1 сая тонн газрын тос экспортлож, улсын төсөвт 180 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон. Мөн нийт зургаан компани газрын тосны хайгуул хийнэ. Хэд хэдэн талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар төлөвлөөд байна. Гэхдээ эхлээд орон нутгийн захиргаа, иргэдээс дүгнэлт, зөвшөөрөл авах ёстой. Хэрэв зөвшөөрөл хоёр талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлана.

-ОУВС, Сангийн яамнаас автобинзен, дизель түлшний импортын онцгой албан татварыг нэмэгдүүлэхэд мэдэгдсэн. Татвар өсөхөөр түлш, шатахууны үнэ нэмэгдэнэ гэсэн хүлээлт иргэдийн дунд үүсээд байна. Үүнийг өсөлтийг саармагжуулахын тулд ямар зохицуулалт хийх вэ?

-Ойрын гурван сарын хугацаанд жижиглэнгийн үнэд өөрчлөлт орохгүй. Үүнээс хойш Шатахууны үнийн зөвлөл болон Сангийн яамны шийдвэрээс



хамаарч үнэ өсөхийг үгүйсгэхгүй. Тиймээс энэ өсөлт иргэдэд хүнд дарамт болохоос сэргийлэх арга зам эрэлхийлж байна. Одоогоор эцсийн шийдвэрт хүрээгүй. Гэхдээ ханшийг огцом буюу 300-400 төгрөгөөр өсгөхгүй байхад анхаарч байна.

-Уул уурхай урагшилж, бүтээн байгуулалт эрчимжлэх цаг ирлээ. Шатахууны эрэлт огцом ихэсдэг энэ үед нөөцөө хэр бэлдэж байна вэ?

-Газрын тосны бүтээгдэхүүн импортлодог Монгол Улсад хангамж маш чухал. Хангамж тасарч, догол үүсэхээр үнэ өсдөг. Үүнтэй зэрэгцээд хувь хүн, аж ахуйн нэгжүүд их хэмжээгээр нөөцөлж, үнэ нэмж буй дамалж зардаг тохиолдол бий.

Энэ хаврын тухайд салбарт олон жил ажиллаж буй компаниуд өмнөх жишгээ даган гурав, дөрөвдүгээр сараас татан авалтаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Манай улсын шатахууны сарын хэрэглээ 60-70 мянган тоннд хэлбэлздэг. Одоогийн байдлаар компаниуд 100 орчим мянган тонн шатахууны нөөцтэй байгаа.

Үүнээс гадна Рашаант өртөөнд 100 мянган тоннын хүчин чадалтай улсын нөөцийн агуулах барихаар олон жил ярьж байна. Энэ төсөлд хувийн хэвшлийн компани Чехээс хөрөнгө оруулалт татахаар ажиллаж байга. Зураг төсөл, баримт бичгийн ажил бүрэн дууссан. Одоо санхүүжилт татахад банкны баталгаа гаргах зэрэг зарим ажил хүлээгдэж буй.

Хэрэв бүтвэл ирэх хавраас ажил нь эхлэнэ. Улс өөрийн мэдлийн шатахууны агуулахтай болсноор хомсдол үүсэх эрсдэл буурна. Цаашлаад үнэ хямд байх үед түлш нөөцлөөд, өсөхөөр нь буцаан нийлүүлж, ханшийн хэлбэлзлийг тогтоон барих боломж бүрдэнэ.

-Дэлхийн зах зээлд газрын тосны ханш унаснаар энэ салбарыг чиглэх хөрөнгө оруулалт буурсан. Харин он гарсаар ханш эргэн сэргэлээ. Үүнийг дагаад Монголын газрын тосны салбарыг чиглэх мөнгөний урсгал хэрхэн өөрчлөгдөх бол. Бас хөрөнгө оруулагчдын хандлага хэр байна вэ?

-Үүнийг хэлэхэд, өнгөрсөн онд хөрөнгө оруулалт сул байсан. Харин энэ оноос газрын тосны үнийн сэргэлтийг дагаад өсөөд байна. Хайгуулын компаниудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг харахад мөнгөний урсгал нэмэгдэх хандлагатай байна.

-Манай зүүн бүсэд газрын тосны хайгуул чамлахааргүй хийсэн. Харин баруун бүсэд энэ чиглэлийн судалгааны ажил төдийлэн хийгээгүй. Энэ бүсэд хайгуулын ажил эрчимжүүлэх үү?

-Увс, Ховд аймагт энэ онд хайгуул хийнэ. Өнгөрсөн онд Увс аймагт хайгуул хийхээр байсан ч орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, зогссон. Тиймээс хайгуулын талаар орон нутгийн иргэдэд сурталчлан таниулаад байгаа. Энэ ажил урагшилна гэж найдаж байна. [ЗГМ]

ДЭЛХИЙД

“Rosneft”-ийн цэвэр ашиг 900 сая ам.долларт хүрв

Б.Ариунболд
Шинжээч

“Rosneft” компани өнгөрсөн онд 52 тэрбум рубль буюу 900 гаруй сая ам.долларын цэвэр ашигтай ажилласан байна. Энэ нь оны эхнээс хоёр дахин өссөн дүн. Компанийн нийт борлуулалт 21 хувиар өсөж, 1.49 их наяд рубль болсон. “Rosneft”-ийн санхүүгийн үзүүлэлтүүд өсөхөд газрын тосны үнэ ханш дэлхийн зах зээлд харьцангуй сэргэсэн нь нөлөөлсөн байна. Мөн өнгөрсөн онд 5.3 тэрбум ам.доллараар газрын тос олборлогч “Баш-

ХУДАЛДАА

Дотоодын борлуулалт 2.4 хувиар буурчээ

Т.Элиса
Шинжээч

Дотоодын борлуулалтад өнгөрсөн онд буурах хандлага ажиглагджээ. Салбарын нийт борлуулалт 13.2 их наяд төгрөг болж, өмнөх оныхоос 2.4 хувиар буурсан. Нийт борлуулалтын 45 хувийг жижиглэн, 55 хувийг бөөний худалдаа бүрдүүлсэн. 2016 оны байдлаар жижиглэн худалдааны борлуулалт долоон хувиар буурсан. Харин бөөний худалдаа 1.8 хувиар өссөнийг Үндэсний статистикийн хорооноос мэдээлэв.

Худалдааг улирлаар нь харвал сонирхолтой өөрчлөлт харгадана. Тухайлбал, хичээлийн шинэ жилийн бэлтгэл хийдэг гуравдугаар улиралд жижиглэн худалдааны үзүүлэлт 2010 оноос хойш тасралтгүй өссөөр иржээ. Гэвч 2016 онд буурсан байна. Харин өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд борлуулалт огцом өссөн. Улирлын дүнгээр 64 хувиар өссөн нь өмнөх онуудын мөн нутгийн иргэдэд сурталчлан таниулаад байгаа. Энэ ажил урагшилна гэж найдаж байна. [ЗГМ]

Есдүгээр сараас нүүрсний

нефть” компанийг худалдан авсан. Энэ нь оны эцсээр борлуулалтад дэмжлэг болжээ.

“Rosneft” компани дээрх худалдан авалтыг хийснээр хувьцаагаа нээлттэй арилжиж байгаа газрын тосны салбарын хамгийн том компани болсон юм. Үүнээс гадна тус компани Ирак, Ливи улстай газрын тосны шинэ хэлэлцээр хийж Ойрхи Дорнодод үйл ажиллагаагаа өргөжүүлнэ гэж мэдэгдлээ. Тус компани Ливийн төрийн өмчит Үндэсний газрын тосны корпорациас түүхий газрын тос худалдан авахаар тохиролцоонд хүрсэн байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

53.2

Хувь. Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 53.2 хувийг эрэгтэй, 46.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

» ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

19.1

Тэрбум төгрөг. Энэ оны эхний сард рестораны орлого өмнөх оны мөн үеэс 19.1 тэрбум, кафеных 9.5 тэрбум төгрөгөөр өсчээ.

» ГАДААД ХУДАЛДАА

39

Хувь. Гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны эхний сард өнгөрсөн оны мөн үеэс 33 хувиар өслөө. Үүнд экспорт 30, импорт 39 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

3.3

Хувь. Гадаад худалдааны нөхцөлийн индекс өнгөрсөн сард өмнөх оны мөн үеэс 40.6, 2017 оны эцсээс 3.3 хувиар өсөж, 1.602-д хүрлээ. Нүүрс, зэсийн экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл сайжирсан байна.

» ИМПОРТ

96

Хувь. Нефть бүтээгдэхүүний импорт 96 хувиар өсөөд байна. Энэ төрлийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос буурсан хэдий ч 2017 оны нэгдүгээр сарын байдлаар тонн тутамд 564.3 ам.долларт хүрч, дөрвөн сар дараалан өсчээ.

» МӨНГӨНИЙ БОДЛОГО

0.75

Хувь. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ удахгүй өсгөнө гэж тус банкны удирдах гишүүдийн олонх нь үзжээ. Тус улсын жишиг хүү 0.5-0.75 хувьд хүрээд байгаа.

1.25

Хувьд. БНСУ-ын төв банк бодлогын хүүгээ 1.25 хувьд хэвээр үлдээлээ. Энэ нь тус улсын мөнгөний бодлогын түүхэн доод цэг юм.

12.25

Хувь. Бразилын төв банк бодлогын хүүгээ 75 нэгжээр танаж, 12.25 хувьд хүргэлээ.

» ДЭЛХИЙД

Нэгж. Евробүсийн үйлдвэрлэлийн салбарын индекс 70 сарын дээд цэгт хүрлээ. Хоёрдугаар сард тус индекс 56 нэгжтэй тэнцжээ.

» ТҮҮХИЙ ЭД

54

Ам.доллар. Олон улсын зах зээлд газрын тосны ханш 0.8 хувиар өсөж, баррель нь 54 ам.долларт хүрлээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2476.02
Евро	2601.68
Япон иен	21.83
ОХУ рубль	42.99
БНХАУ юань	359.97
БНСУ вон	2.17

Сурталчилгаа

Сар шиндгээ
Байхан шиндлээрэй



ШИНИЙН 1-15

**БЭЛЭГНИЙ КАРТ
БҮР БЭЛЭГТЭЙ**

Урамшууллын хугацаа
2017.02.27-03.13

☎ 2222, 1800-2222 бусад
сүлжээнээс



MobiComOfficial



www.mobicom.mn



Шинийн 1-нээс шинийн 15-ны хооронд сар шинийн бэлэгний картаар дансаа цэнэглэсэн урьдчилсан төлбөрт болон хосолсон төлбөрт хэрэглэгчдэд

- Сүлжээндээ яриа, мессэж, дата 24 цаг хязгааргүй
- Сүлжээндээ яриа 24 цаг хязгааргүй
- Сүлжээндээ мессэж 24 цаг хязгааргүй
- 24 цаг хязгааргүй дата багц ашиглах эрхийн аль нэг нь бэлэг болон очно.

Та бэлгээ цэнэглэсэн хугацаанаас хойш 24 цагийн турш ашиглаарай.